



ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ  
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

# ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ

СЭТГҮҮЛ

№05  
2024 ОН

2024.11.05



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ  
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ:



Газар ээжийн үр шимийг хүртэж,  
хүн ардаа эрүүл хүнсээр хангах  
их үйлсэд хөдөлмөр зүтгэлээ  
зориулж ирсэн

**САЛБАРЫН БАЯЛАГ ТҮҮХИЙГ  
БҮТЭЭГЧИД, ҮЕ ҮЕИЙН  
ТАРИАЛАНЧИД, САЛБАРЫН  
МЭРГЭЖИЛТНҮҮД**

**ТА БҮХЭНД**

Монголын ард түмний нэрийн  
өмнөөс гүн талархал  
илэрхийлье.



WWW.HUNSNIIHUVISGAL.MN





ХӨРС ЭРҮҮЛ БОЛ  
**ХҮНС** ЭРҮҮЛ



ХҮНС ЭРҮҮЛ БОЛ  
**ХҮН** ЭРҮҮЛ



# Агуулга

12

ТҮҮХЭН ШИЙДВЭР  
ТҮҮХЭН ХЭРЭГЖИЛТ  
ТҮҮХЭН ҮР ДҮН

17



Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн дэлхийн зах зээлд гарахад төрийн тэргүүний харилцан айлчлалууд чухал үүрэг гүйцэтгэнэ

26

“ХҮНСНИЙ ХАНГАМЖ,  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ”  
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ  
ХҮРЭЭНД ХЭН, ХЭРХЭН  
АЖИЛЛАЖ БАЙНА ВЭ?

28

Пестицид хэрэглэх стандарт мөрддөггүй нь байгаль орчныг бохирдуулахаас гадна олон төрлийн өвчин, хавдар үүсгэдэг



32

АЛТАН НАМАР 2024  
ургацын баяр



38

ҮР ДҮНГИЙН БУУХИА  
ҮРГЭЛЖИЛСЭЭР...



42

ҮЙЛ ЯВДЛЫН  
ХУРААНГУЙ

54

“ХҮНСНИЙ  
ХУВЬСГАЛ”-ЧИД



58

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
“БУЛГАН СҮҮЛ”-ТЭЙ  
САНААЧИЛГА





## Мэндчилгээ

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ

Эрхэм хүндэт хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын үе үеийн ажилтан, албан хаагчид аа,

Эрхэм хүндэт малчид, тариаланчид, үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчид ээ!

Та бүхэнд Монгол Улс Атар газар эзэмшсэний түүхт 65 жил болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Монголчууд бид эрт дээр үеэс эцэг тэнгэр, эх дэлхий хэмээн байгаль дэлхийгээ дээдлэн шүтэж, зохицон амьдарч, өсөн үржиж, урган төлждөг хөдөө аж ахуйн нөөц баялгаа зүй зохистой ашиглаж, хүн ардынхаа аж амьдралыг тэтгэж ирсэн түүхтэй.

**Өнгөрсөн түүхэн цаг хугацаанд Монголчууд бид газар тариалангийн салбараа дэмжиж, улс орон, ард иргэдийнхээ хүнсний хэрэгцээг хангах, экспортлох зорилгоор Атрын гурван удаагийн үндэсний хэмжээний аяныг амжилттай өрнүүлж байсан.**

Атрын анхдугаар аян 1959 онд эхэлж, 10 сангийн аж ахуй шинээр байгуулагдаж, үр дүнд нь 1959-1965 он буюу 6 жилийн дотор 1 сая орчим га атар газрыг эзэмшиж, анх удаа 516 мянган тонн үр тариа хураан авсан бахдам амжилт гаргаж байлаа.

Мөн газар тариалангийн салбарын үндэсний мэргэжилтэн, боловсон хүчин бэлтгэх их, дээд сургууль, техник мэргэжлийн сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд үүсгэн байгуулагдсан нь Атрын анхдугаар аяны гол үр дүн нь байсан юм.

Атрын хоёрдугаар аян 1976 онд эхэлж, үр дүнд нь 1989 оны байдлаар 1.2 сая га эргэлтийн талбайтай, жилдээ тариалах талбай 837 мянган га-д хүрж, 840 мянган тонн үр тариа, 155 мянган тонн төмс, хүнсний ногоо, 1 сая гаруй тонн таримал тэжээл, хадлан хураан авч байлаа.

Цаашлаад нийгэм, эдийн засгийн шилжилтийн үе нь хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хүндхэн сорилт бэрхшээл учруулсан.

Тухайлбал, шилжилтийн он жилүүдэд газар тариалангийн эргэлтийн талбайн 60 гаруй хувь, машин техник, трактор, комбайны 90 гаруй хувийг бүрэн ашиглаж чадахгүй нөхцөл байдал үүсэж байсан.



“Алтан намар-2024” ургацын баярын хүрээнд зохион байгуулагдсан хүнсний ногоо, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа

Энэхүү хүнд үед үр тариа, гурилынхаа 70 гаруй хувь, төмс, хүнсний ногооны 50 гаруй хувийг гаднаас импортоор авч, үр тарианы ургацын хэмжээ 2005 он гэхэд 77 мянган тонн буюу атрын хоёрдугаар аяны үеийн 840 мянган тонноос даруй 90 гаруй хувиар буурсан үзүүлэлт гарч байлаа.

Харин Монгол Улсын Засгийн газар 2008-2010 онд Атрын гуравдугаар аян болох тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг дэвшүүлэн хэрэгжүүлснээр уг салбарт хөнгөлөлт чөлөөлт, дэмжлэг туслалцаа үзүүлж, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлснээр тариалангийн эргэлтийн талбайг 650 мянган га-д хүргэн сэргээж, улаанбуудай, төмсөөр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж чадсан нь Атрын гуравдугаар аяны гол үр дүн байлаа.

Газар ээжийн үр шимийг хүртэж, хүн ардаа эрүүл хүнсээр хангах их үйлсэд хөдөлмөр зүтгэлээ зориулж ирсэн энэ салбарын баялаг түүхийг бүтээгчид, үе үеийн тариаланчид, салбарын мэргэжилтнүүд Та бүхэнд монголын ард түмний нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

Эрхэм нөхөд өө,

Монгол төрийн бодлогын цөмд монгол хүн, монгол өрх байж ирсэн, цаашид ч байх учиртай.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын нэг чухал асуудал нь Монгол хүнийг эрүүл аюулгүй орчин, найдвартай, эрүүл хүнсээр хангах явдал юм.

Тиймээс бид байгаль орчин, хүнсний хангамж, аюулгүй байдалдаа онцгой анхаарах ёстой.

Уур амьсгалын өөрчлөлт, тэр дундаа цөлжилт, хөрсний доройтол, шороон шуурга жил ирэх тусам эрчимжиж, цас зуд, ган гачгийн давтамж нэмэгдсээр байна.

Энэхүү цаг агаарын таагүй нөхцөл байдал нь манай улсын уламжлалт хүнс, хөдөө аж ахуйн салбарт хүндээр тусаж, монголчууд бидний аж амьдралд ихээхэн сорилт, бэрхшээл учруулж байна.


Тиймээс уур амьсгалын өөрчлөлттэй бодит үр дүнтэй тэмцэх, улмаар тогтвортой хөгжлийн зорилтуудаа амжилттай ханган хэрэгжүүлэхэд Монголчууд бид онцгой анхааран ажиллах шаардлагатай байна.



Шилмэл малын үзэсгэлэн, дуудлага худалдаа



Хүнсний ногоо, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа



Хүнсний ногоо, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааны нээлт



Шилмэл малын үзэсгэлэн, дуудлага худалдаа



Ялангуяа, байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийг дэмжсэн байдлаар хүнс, хөдөө, аж ахуйн салбарыг хөгжүүлэх асуудал чухал байна.

Тиймээс уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, хөрсний доройтол, шороон шуургатай үр дүнтэй тэмцэх, ард иргэдээ эрүүл хүнсээр хангах зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгч “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл монгол хүн” болон “Цагаан алт” зэрэг үндэсний хөдөлгөөнүүдийг улс орон даяар санаачлан хэрэгжүүлж байгаа билээ.

Зөвхөн “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд төр, захиргааны 35 байгууллага хамтран ажиллаж, хууль дүрэм, төсөв санхүү, хөнгөлөлттэй зээл, гааль татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөс эхлүүлээд 114 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Өнгөрсөн 2 жилийн хугацаанд арилжааны банкаар дамжуулан, 5-6 хувийн хүүтэй, 3-5 жилийн хугацаатай, нийт 1.3 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг төр засгийн зүгээс 3100 орчим хүнс үйлдвэрлэгч, баялаг бүтээгч иргэн, ААН-д олгоод байна. Үр дүнд нь хүнсний салбарт нийт 24 хүнсний үйлдвэр шинээр ашиглалтад орж, өнгөрсөн 2023 оны байдлаар хүнсний ногооны хэрэгцээний 85 хувийг дотоодоосоо хангаж чадсаныг хэлэхэд таатай байна.**

Ийнхүү дээрх үндэсний хөдөлгөөнүүдийг амжилттай хэрэгжүүлснээр байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжилд шинэ боломж нээгдэж, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжил хангагдах, худалдаа, экспорт, хөрөнгө оруулалт, ажлын байр

нэмэгдэх, ядуурал буурах зэрэг олон эерэг үр дүнд авчирна гэдэгт Төрийн тэргүүн итгэл төгс байна.

Ингэснээр манай улс хөгжин дэвжиж, ард иргэд маань амар тайван, эрүүл аюулгүй орчинд амьдарч, мөнгөлчүүд бидний “ҮНДЭСНИЙ БАЯЛАГ” арвижин дэвжинэ.

Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилсан “100 жил – 10 зорилт” хөгжлийн санаачилга, “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичиг болон бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Монгол Улс “ЭРҮҮЛ ХҮНС ҮЙЛДВЭРЛЭГЧ, ХҮНС ЭКСПОРТЛОГЧ УЛС ОРОН” болох тодорхой зорилт туссан.

**Энэ хүрээнд Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгууд буюу төвийн бүсийг “ХӨДӨӨ АЖ АХУЙН ТӨРӨЛЖСӨН, АЖ ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮС” болгон хөгжүүлэхээр зорьж байгаа бөгөөд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг Дархан-Уул аймагт шилжүүлэн байршуулахаар Улсын Их Хурал, Засгийн газраас шийдвэр гараад байна.**

Энэ шийдвэрийн үр дүнд сургалт, судалгаа, үйлдвэрлэл, төрийн байгууллагуудын төвлөрөл бий болж, шинжлэх ухаан, технологи, инновацад тулгуурласан, байгаль орчинд ээлтэй, тогтвортой хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил, үр дүнд гарна гэж ард түмэн хүлээж байна.

Тиймээс та бүхэн үүрэг хариуцлагаа гүнээ ухамсарлаж, улс орныхоо хөгжил дэвшлийн төлөө улам эрч хүчтэй, идэвх санаачилгатай, үр дүнтэй, сэтгэл гарган сайн ажиллаарай.

Эх орноо эрүүл хүнсээр хангах их үйлсэд хүнс, хөдөө аж ахуйн салбарын ажилтан, албан хаагчид,



“Алтан намар-2024” ургацын баярын хүрээнд зохион байгуулагдсан техникийн парад.

Үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчид Та бүхний дэмжлэг, манлайлал, хамтын ажиллагаа, харилцан ойлголцол хамгийн чухал гэдгийг мөн онцлон тэмдэглэе.

Эрхэм төрийн түшээд, баялаг бүтээгчид ээ,

Цаашид байгаль орчинд ээлтэй, бүсчилсэн хөгжил болон тогтвортой хөгжлийг дэмжсэн газар тариалангийн салбарыг хөгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн зүгээс дараах асуудалд анхаарал хандуулж хамтран ажиллах нь зүйтэй байна.



“Алтан намар-2024” ургацын баярын хүрээнд зохион байгуулагдсан шилмэл малын үзэсгэлэн, дуудлага худалдаа

Үүнд:

- Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, шороон шуургыг бууруулж, ногоон хөгжлийг дэмжсэн, дэвшилтэт технологи, инновацад суурилсан, дэлхийн жишигт нийцсэн, экспортод чиглэсэн газар тариалангийн салбарыг хөгжлийн шинэ түвшинд гаргах цогц шинэчлэл, бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Бүсчилсэн хөгжлийг дэмжсэн газар тариалангийн кластер, цогцолборуудыг байгуулах, түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын нэгдсэн тогтолцоо, жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулах, тээвэр логистикийн оновчтой сүлжээг бий болгох, боловсон хүчнийг бэлтгэх;
- Эрүүл ахуй, чанарын асуудлыг шат шатандаа анхаарч, аюулгүй байдлын хяналтыг эрс чангатгах;
- Төсөв, хөрөнгийн нөөц боломжоо бүрэн дүүрэн зөв ашиглаж, зээл санхүүжилт, татвар, даатгал зэрэг санхүүгийн хөшүүргүүдийг оновчтой, хүртээмжтэй ашиглаж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааг дэмжих зэрэгт анхаарах шаардлагатай байна.

**Дээрх зорилтуудыг төр, хувийн хэвшлийн оновчтой хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлснээр ард иргэдээ гарал үүсэл нь тодорхой, найдвартай, дотоодын эрүүл хүнсээр хангаж, ажлын байрыг нэмэгдүүлж, монгол хүний амьдралын чанар сайжирч, улмаар манай улс хүнс экспортлогч орон болох боломж бүрдэнэ.**

Улс орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдал, хөгжил дэвшил, үр хүүхдүүдийнхээ гэрэлт ирээдүйн төлөө төр, засаг, түмэн олноороо нэгдэн нийлж, эх оронч сэтгэлээр хамтран зүтгэцгээе.



Алтан шаргалтах тариан талбайн ургац нь арвин байж, Ажилсаг хичээнгүй тариаланчдын үйлс нь өөдрөг байх болтугай!

Мөнх тэнгэрийн хүчин дор Монгол Улс мандан бадрах болтугай!



“Алтан намар-2024” ургацын баярын хүрээнд зохион байгуулагдсан техникийн парад.

Хүнс, хөдөө аж ахуй,  
хөнгөн үйлдвэрийн сайд  
Ж.Энхбаяртай “Хүнсний  
хувьсгал” үндэсний  
хөдөлгөөний талаар  
ярилцлаа.



ХХААХҮ-ийн сайд

**Ж.Энхбаяр:**

“Хүнсний хувьсгал” -  
ын үр дүнд импортын  
хамааралтай дотоодын  
бүтээгдэхүүний  
үйлдвэрлэл нэмэгдэж  
байна

➤ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Дархан-Уул аймаг руу нүүж байна. Яагаад заавал нүүх болсон юм бэ?

- Монгол Улсын эдийн засаг уул уурхайгаас хэт хамааралтай тул алт, нүүрс, зэсийн үнэ унахад манай эдийн засагт савлагаа үүсэж ирсэн. Тиймээс эдийн засгийг солонгоруулах, төрөлжүүлэх тал дээр Засгийн газар анхаарч, Төвийн бүс буюу Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгийг хөдөө аж ахуй, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрийн тулгуур бүс, аж үйлдвэрийн алтан гурвалжин болгож, эдийн засгийн шинэ гарц болгон хөгжүүлэхээр зорьж байна. Монгол Улсын Засгийн газар ХХААХҮЯ болон түүний харьяа газруудыг Дархан-Уул аймаг руу шилжүүлэн байршуулах шийдвэр гаргаснаар, харьяа газрууд болон яамны эхний ээлжийнхэн Дархан-Уул аймаг руу нүүж очоод байна. Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал”, “Тэрбум мод”, “Цагаан алт” тэргүүтэй үндэсний томоохон хөтөлбөрүүд харилцан уялдаа холбоотойгоор хэрэгжихэд маш том түлхэц болно.

Үйлдвэрлэдэггүй ард түмэн ирээдүйгээ алддаг, үйлдвэрлэдэггүй ард түмэн итгэл үнэмшлээ алддаг. Түүнчлэн тусгаар тогтнолоо алддаг. Иймд Монгол Улс импортлогч биш үйлдвэрлэгч орон болох ёстой. Төвийн бүс Монгол Улсын ХХААХҮ-ийн салбарын хөгжлийн гол түлхүүр байх болно гэж үзээд ХХААХҮЯ-ыг Дархан руу нүүлгэж байгаа юм. Төвийн бүсийн хөгжлөөс Монгол Улсын ирээдүй шалтгаална. Тиймээс орон нутаг руу нүүсэн анхны яам болж байна.

➤ Монгол Улс гэлтгүй дэлхий нийт хүнсний аюулгүй байдалдаа маш их анхаарч байна. Хэрэв “Хүнсний хувьсгал”-ыг эхлүүлээгүй бол эрсдэл байсан уу?

- Дэлхий нийтийг хамарсан “Ковид-19” цар тахлын үед хойд, урд бүх хил хаагдаж, агаарын орон зай ч бүрэн зогсож дэлхий нийтээс бид тусгаарлагдсан хүнд үе байлаа. Засгийн



газар яаралтай арга хэмжээ авч хөл хорио тогтоосон, “Ковид 19”-ийг дотооддоо нэг сар алдахад л монголчууд хүнсний картын бараанд орохоос өөр ямар ч сонголтгүй болсон хүнд үе байсан. Хүнсний аюулгүй байдал, хүнсний нөөц, хангамж ямар хэмжээнд доройтож, алдагдсан нь цар тахлын үед илүү тод ажиглагдсан. Монголчууд хүнсний импортын хамаарал дунд амьдарч, валютын урсгал зогсох нь бүү хэл улам эрчимтэй нэмэгдэж байгааг Монгол Улсын Ерөнхийлөгч, ҮАБЗ-ийн тэргүүнд танилцуулахад Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ҮАБЗ-ийн хурлыг яаралтай хуралдуулж, шийдэх үүрэг өгсөн. Тухайн үед би ҮАБЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байлаа. ҮАБЗ дээр хөтөлбөрийн агуулга, хэрэгжилт, үр дүн зэрэг тооцоо судалгаа хийгдэж “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн эхэлж байсан юм.

Монгол Улс гол нэр төрлийн 19 хүнсний бүтээгдэхүүнийг эх орондоо үйлдвэрлэдэг, ургуулдаг байх шаардлага үүссэн. Улмаар хөдөө аж ахуйн салбарын асуудлыг цоо шинээр харах шаардлага бий болж, Монгол Улсын Ерөнхийлөгч “Хөрс эрүүл бол хүнс эрүүл. Хүнс эрүүл бол монгол хүн эрүүл. Энэ бол Монгол Улсын хөгжлийн баталгаа” хэмээн тодорхойлж энэхүү “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийг санаачлан өргөн барьсан.

Хөтөлбөр хэрэгжсэн хоёр жилийн хугацаанд гадагшаа алддаг байсан 120 гаруй сая ам.доллар буюу 400 гаруй тэрбум төгрөгийг дотооддоо үлдээж чадсан. Улаанбуудай, үр тарианы салбар босоод ирэхээр эрчимжсэн мал аж ахуй, гахай, тахианы ферм, мах, сүүний үйлдвэр аж ахуйн нэгжүүд мөн дагаад бий болж байна.

Нөгөө талаас, дэлхий дахинд байгаль, цаг уурын асар их өөрчлөлт явагдаж, дэлхийн хүн амын өсөлт эрчимтэй нэмэгдэж, 2050 онд хүн ам есөн тэрбумд хүрнэ. Тиймээс хүнс бол онцгой, нэгдүгээр асуудал болж хувирч байна гэсэн үг.

Дэлхийн цэрэг, стратегийн орчин ч мөн хүндэрч, шулуухан хэлэхэд бидний 30 жилийн амар амгалан байдал нурж байна. Улс орнууд зэвсэглэж, мөргөлдөөний байдалд шилжсээр л байгаа. Үүнийг дагаад хүнсний үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, дотоод үйлдвэрлэлээ сайжруулж байна. Дэлхий нийтээр болзошгүй сорилтыг даван туулах бэлтгэлээ хийж байхад бид гар хумхиад суугаад байж болохгүй.

Ямар ч дайн дажинтай, өвчин тахалтай хүнд үед энэхүү 19 төрлийн хүнсний бүтээгдэхүүнээ дотооддоо үйлдвэрлэж байхад бид даван туулж чадна гэсэн бодлого энэхүү хөдөлгөөний ард байгаа. Бид гэлтгүй дэлхий нийтийн амар амгалан цаг хугацаа дуусаж байна. Эрсдэл байсан, одоо ч байгаа, цаашид ч байна. Хамгийн гол нь эрсдлийг даван туулах, сөрөн тэсвэрлэх, тогтвортой байдлаа хамгаалах, хадгалах чадавхтай байх нь чухал.

► **“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний үр дүн, салбарт ямар өөрчлөлт гарч байна вэ?**

- “Хүнсний хувьсгал” хэрэгжсэн хоёр жил гаруйн хугацаа асар богино мэт боловч их ажлын ард гарч чадсан. Энэ хүрээнд хүнсний ханган нийлүүлэлтийн сүлжээний үе шат бүрд буюу түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, тээвэрлэх үйл ажиллагаанд санхүүгийн болон бодлогын дэмжлэгийн олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Тухайлбал, хууль эрхзүйн орчны өөрчлөлт, шинэчлэл хийгдэж, Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн болон хүнсний үйлдвэр, аж ахуй шинээр байгуулагдан, зах зээлд 200 орчим шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлэгдэж эхэлсэн. Өнгөрсөн оны статистикийн мэдээгээр дотоодын өндөгний үйлдвэрлэл 7.9 хувиар, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3.4 хувиар, хүнсний ногооны үйлдвэрлэл төрлөөс хамаарч 7.7-20.9 хувиар, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл





1.2 хувиар тус тус өсч, импорт мөн хэмжээгээр буурлаа. Ерөнхийлөгчийн санаачилсан “Цагаан алт”, “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөдөлгөөн, “Атрын-IV” аянтай уялдаж, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүн нь “Хүнсний хувьсгал”-ын хэрэгжилт үр дүнд маш сайн нөлөө үзүүлнэ. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийг дараагийн шатанд гаргах цаг ирсэн байна.

➤ **“Хүнсний хувьсгал” хөдөлгөөний хүрээнд хөдөө аж ахуйн салбарынханд ямар ямар дэмжлэг хүрсэн бэ. Хэдэн төгрөгийн зээл олгосон бэ?**

- Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүрээнд 2023-2024 оны есдүгээр сарын байдлаар нийт 1,192.8 тэрбум төгрөгийг эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээлийн хэлбэрээр нийт 3113 аж ахуйн нэгж, иргэнд олгоод байгаа. Уг зээлийг арилжааны 10 банкаар дамжуулан улсын төсвөөс зээлийн хүүгийн 13 хувь хүртэлх хувьд нь хүүгийн хөнгөлөлт олгосон. Нийт зээлийн 61.7 хувь нь хүнсний боловсруулах үйлдвэр, сав баглаа боодлын үйлдвэрлэлийг, 30.1 хувь нь газар тариалангийн үйлдвэрлэлийг, 8.1 хувь нь мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зориулалтаар олгогдсон. Нийт зээлийн 50.3 хувь нь эргэлтийн хөрөнгийн зээл байгаа.

➤ **“Хүнсний хувьсгал” хэрэгжсэнээр Монгол Улсын хүнсний аюулгүй байдалд ямар ахиц гарсан бол. 19 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотооддоо тарьж, ургуулж, бойжуулдаг болсон уу?**

- Хүнсний аюулгүй байдал гэдэг нь хүнсний хангамж, хүртээмж, шим тэжээл, аюулгүй байдлыг багтаасан цогц ойлголт. “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд хүн амын өдөр тутмын хэрэгцээний хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах, хүртээмжийг сайжруулах, үүнд шаардлагатай хууль эрхзүйн шинэчлэл, удирдлага зохион байгуулалт, эрдэм шинжилгээ, судалгааны институци, чадавх, анхан шатны үйлдвэрлэлээс бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэн гарах үе шат бүрт үйлдвэрлэл эрхлэгчдэд бодлогын болон хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж байгаа. “Хүнсний хувьсгал”-ын үр дүнд дотоодод үйлдвэрлэдэг боловч импортын хамааралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж байна. Тухайлбал, өндөг, төрөл бүрийн ил талбайн

болон хүлэмжийн ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүн, ургамлын тосны үйлдвэрлэлд ахиц гарч эхэлсэн. Харин импортоос шууд хамааралтай цагаан будаа, элсэн чихэр зэрэг бүтээгдэхүүний түүхий эдийг тариалах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хөнгөлөлттэй зээлийн шугам нээлттэй байгаа гэдгийг хэлье.

➤ **Монголчууд хэзээ дотооддоо хүнсний бүтээгдэхүүнээ 100 хувь үйлдвэрлэж, гадаадад экспортолох боломжтой вэ. Экспортод нэн тэргүүнд гарах боломжтой ямар бүтээгдэхүүн байна вэ?**

- Бидний өмнөө тавьсан бас нэг томоохон зорилт бол Монгол Улсын эдийн засагт хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, салбарын экспортын орлогыг 2-3 тэрбум ам.долларт хүргэх юм. Хүнсний хувьсгалаас гадна дээр дурдсан бодлогын томоохон хөдөлгөөн арга хэмжээнүүдийн үр дүн бидэнд хүнсний хангамж, аюулгүй байдлаа чадавхтай болгон бэхжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлнэ. Гэхдээ бид аливаа гадаад, дотоод эрсдлийг тооцож, илүү цэгцтэй, харилцан уялдаатай, тодорхой, нээлттэй байх ёстой. Хүнсний бүтээгдэхүүнээс мах, махан бүтээгдэхүүний экспортын боломж хамгийн өндөр. Сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, жимсгэнэ, хүнсний ногоо, тэдгээрээр боловсруулсан бусад хүнсний экспорт тодорхой хэмжээнд хийгдэж байгаа. Түүхий эдээр нь биш аль болох өртөг шингэсэн бэлэн, хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх нь чухал байна. Импортлогч орны тоог нэмэгдүүлэх, тарифын нэн таатай нөхцөлтэй гадаад зах зээлийг нээх чиглэлээр ажлууд хийгдэж байна. Монгол хүнс амт чанар, бүтээгдсэн түүхээрээ ялгарах, үнэ цэнтэй байхад анхаарал хандуулах нь зүйтэй.

➤ **Цаашид “Хүнсний хувьсгал”-н хүрээнд ямар ажил хийх вэ?**

- Монголчууд эрүүл хүнс хэрэглэхийн тулд хөрс хамгаалалдаа анхаарах цаг болсон. Манай оронд цаг агаар, хүний хүчин зүйлийн нөлөөгөөр хөрсний эвдрэл маш эрчимтэй явагдаж, хөрсний чийгийн дутагдалд орох болсон. Тиймээс Монгол Улсын 1.1 сая га тариалангийн талбайг бүрэн ойжуулж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнтэй хослуулан ойн зурвас байгуулах зорилт тавин ажиллаж байна. Ингэснээр ургац 25 хувиар нэмэгдэж, Төрийн тэргүүний санаачилсан “Тэрбум



мод” үндэсний хөдөлгөөн хамтдаа цогц болон хэрэгжих алхмууд хийгдэнэ. Хөрсний үржил шим муудаж, жилд 10 мянган тонн бордоо импортоор авч, 10 мянган тонн органик бордоо дотооддоо үйлдвэрлэж байгаа нь маш бага үзүүлэлт юм. Бордооны дотоодын үйлдвэрлэлийг эрс нэмэгдүүлэхэд анхаарна.

Манай улс жилдээ 70 мянган тн үр тариа, 45 мянган тн тэжээлийн ургамал, хүнсний ногооны 35 мянган тн, төмсний 48 мянган тн үр хэрэглэж байна. Үүний дийлэнхийг импортоор авсан хэвээр байгаа тул дотооддоо үр сортын аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх, шинэ сортын үр гарган авч нутагшуулах зорилт дэвшүүлсэн.

1980 онд Монгол Улс 89 мянган га талбайг усжуулж, 115 мянган усжуулалтын систем ажиллаж байсан бол өнөөдөр 10 мянган гаруй усалгааны системтэй болж, уналтад орсон. Иймд усжуулалтыг дахин идэвхжүүлж 30 мянган га талбайг нэмж усжуулна.

Мөн “Хүнсний хувьсгал”-ын үр дүнд тариалан эрхлэгч, ногоочдын 60 хүртэлх хувь нь техникийн шинэчлэл хийж чадсан бол тэжээлийн ургамлын тариалалтыг эрс нэмэгдүүлэх шаардлагатай байгаа. Нүүдлийн мал аж ахуйгаа байгаль цаг уурын эрсдлээс хамгаалах, нөгөө талд нь гахай, тахиа, сүүний аж ахуйг хөгжүүлэхийн тулд тэжээлийн аж ахуй, хүнсний ногооны салбарыг 100 хувь механикжуулах зорилт тавьж байна.

Мөн үр цэвэрлэгээний иж бүрэн автомат үтрэмүүдийг олноор байгуулж, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, өвлийн хүлэмж, төмс хүнсний ногооны механикжсан агуулах зорилго хүртээмж хангамжийг нэмэгдүүлэх зорилго тавьж байгаа. Төвийн бүсэд алим, чавга, интоорын төрлийн жимснүүд бүрэн

болж ургацаа өгч эхэлсэн. Тиймээс Төвийн бүсэд жимсний аж ахуйн салбарыг эрчимтэй хөгжүүлэхийг зорьж байна. Дөрвөн улирлын ухаалаг хүлэмжид шилжиж байж хүнсний ногоогоо бид дотооддоо бүрэн хангана. Ургац, бүтээмж нэмэгдэж байгаа энэ цаг үед орчин үеийн механикжсан ногооны, хүнсний хөргөлт болон халаалттай зоориудыг 170 мянган тонноор нэмэгдүүлж байж тарьсан ногоогоо бүрэн хадгална гэж үзээд үүнд зорин ажиллаж байгааг дуулгая.

Энэ жил 106 мянган га-д малын тэжээл тариалж, 208 мянган тонн тэжээл авч байгаа нь нийт малчдын сэтгэлгээнд өөрчлөлт гарсан гэдгийг харуулж байгаа юм. Тэжээлээ тариалж байгаль цаг уурын эрсдэлээ малаа хамгаална гэдгээ ойлгож эхэлсэн. Вандуй, эрдэнэшиш, наранцэцэг, тосны ургамлуудыг эргэлтэд оруулна. Хүнсний дотоодын хэрэгцээг хангахын тулд 100 мянган га талбайд дахин шинээр эргэлтэд оруулах шаардлага үүсэж байна.

Мал аж ахуйн салбарт гэхэд 70 сая малаас 117 мянга нь өндөр ашиг шимт малд тооцогдож байгаа. Жилд монгол үнээнээс 2000 мянган тонн сүү авч байгаа бол дэлхийн стандарт 10-12 мянган тонн болсон. Тиймээс малын үүлдэрлэг байдлыг мах, сүүний чиглэлд бүсчилэн үржүүлж, ашиг шимт малын тоо толгойг 200 мянгаар нэмэгдүүлнэ.

Төвийн бүсэд Монгол Улсын хүн амын 53, үр тарианы үйлдвэрлэлийн 68.2, төмсний 77.5, хүнсний ногооны 71.7, хүлэмжийн үйлдвэрлэлийн 99 хувь, хөнгөн хүнсний үйлдвэрийн 90, тэжээлийн үйлдвэрлэлийн 99 хувь нь байршиж байна. Тиймээс Хүнс, хөдөө аж ахуйн яамны гол бодлого Төвийн бүсэд чиглэж байгаа.

*Ярилцсан: Э.Энхболд*





## Дэлхий дахинд хүчээ авч буй хүнсний хямралыг сөрөх нь

2022 онд ОХУ Украины дайн, Тайваны хоолойн хямрал, цар тахал, хүнсний худалдааны саатал, дэлхийн санхүү, эдийн засгийн шок, Европын эрчим хүчний хямрал зэрэг томоохон үндэстэн дамнасан бэрхшээл тулгарсан жил байв.

Дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй дээрх асуудлууд нь хэтдээ дараагийн том сорилт хүнсний хомсдол, “хүнсний хямрал”-д хүргэх нь тодорхой байлаа.

Цар тахлын дараа дэлхий дахинд тээвэр ложистикийн хүндрэл, ажилгүйдэл, ядуурал, бараа бүтээгдэхүүний хомсдол, үнийн өсөлт зэргээс шалтгаалан хүнсний хангамж, аюулгүй байдал нь улс бүрийн өмнө нэн тулгамдсан асуудал болж байв. Дэлхийн зах зээлд хүнс болон бордооны үнэ 14 жилийн хугацаанд байгаагүйгээр хамгийн өндөр хувиар өсөв. Ялангуяа үр тариа, ургамлын тосны үнэ огцом өсөж, бага орлоготой иргэдийн амьжиргаа, хүнсний аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулсан. 15 жилийн хугацаанд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр 43 хувиар, түүний дотор үр тарианы үнэ 56 хувиар өсөв. Гуравхан сарын хугацаанд бордооны үнэ 20 хувиар өссөн байна.

НҮБ-ын судалгаагаар 2021 оны байдлаар дэлхийн 53 орны 190 сая гаруй хүн хүнсний аюулгүй байдлын эрсдэлд орсон байна. Дэлхийн бусад улс, ялангуяа манай хоёр хөрш улс хүн амынхаа хүнсний аюулгүй байдалд ихээхэн анхаарч эхэлсэн бөгөөд манай улс 2021 онд гэхэд нэг тэрбум ам.доллараар хэмжигдэх хүнсний бүтээгдэхүүнийг импортлосон байлаа. Өөрөөр хэлбэл импортын хамаарал 48 хувь буюу хүнсний хангамж өндөр эрсдэлтэй байдалд орсон юм.

Олон зуун жилийн нүүдлийн мал аж ахуйн соёлтой, 70-аад сая малтай, сүү, сүүн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангах нөөц бололцоотой манай улс хоолны давсаа хүртэл “айлаас гуйн” хэрэглэж байгаа нь эмгэнэл юм. Иймд Ямар ч цаг үед монголчууд эрүүл, аюулгүй дотоодын хүнсээр эх орноо бүрэн хангадаг болох нь чухал гэж үзэн Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний анх санаачилж байв.

# ТҮҮХЭН

## Ерөнхийлөгчийн санаачилга түүхэн шийдвэр болох нь

Улс орныхоо нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор “Халамжаас хөдөлмөрт, Олборлолтоос боловсруулалтад, Импортоос экспортод” шилжих суурь реформын хүрээнд “100 жил – 10 зорилт” хөгжлийн санаачилгыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Төрийн тэргүүн дэвшүүлсэн.

Энэхүү санаачилгын нэг зорилт нь дээр дурдсанчлан “Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, мал аж ахуй, газар тариалангаа эрчимжүүлэн хөгжүүлж, бүс нутагтаа органик хүнс экспортлогч улс болох” юм. Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч 2022 оны тавдугаар сарын 13-ны өдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг хуралдуулж, зөвлөмж гарган, УИХ-ын чуулганы хуралдаанд дэлгэрэнгүй мэдээлэл хийж, улс орон даяар “Хүнсний хувьсгал” эхлүүлсэн. Үүний дараа “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоол батлагдаж энэхүү хөдөлгөөн албан ёсоор эхэлсэн юм. Тухайн цаг үед үндэсний үйлдвэрлэгчид, төр, хувийн хэвшил, эрдэмтэн судлаачид “Түүхэн шийдвэр” гарлаа гэж баярлаж байв.

Таван бүлэг, 49 заалт, 116 арга хэмжээнээс бүрдэх УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд Монгол Улс 19 гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо бүрэн хангаж, цаашлаад бүс нутагтаа экспортлогч улс болохоор зорьсон. Мөн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах, салбарын удирдлага зохион байгуулалт, мал аж ахуй, газар тариалан болон хүнсний боловсруулах үйлдвэрийн чиглэлээр хийж хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг тодорхойлж, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн юм.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх үндэсний үйлдвэрлэгчидтэй биечлэн уулзаж, үйлдвэрт нь ажиллан, санал хүсэлтийг нь сонссон. Энэ хүрээнд үйлдвэрлэгчдэд хамгийн их тулгамддаг асуудлыг шийдэж бага хүүтэй, урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийг олгох болсон нь үндэсний үйлдвэрлэгчдийн “нурууг тэнийлгэж” чадсан.





# ШИЙДВЭР ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН



## “Хүнсний хувьсгал” хоосон уриа үг биш

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд арилжааны банкаар дамжуулан, 5-6 хувийн хүүтэй, 3-5 жилийн хугацаатай, нийт 1.3 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг төр засгийн зүгээс 3100 орчим хүнс үйлдвэрлэгч, баялаг бүтээгч иргэн, ААН-д олгоод байна.

Мөн экспортын нөөц боломж өндөртэй хүнс, хөдөө аж ахуйн нийт 19 төрлийн үйлдвэрлэлд нэн шаардлагатай 428 төрлийн тоног төхөөрөмжид импортын гаалийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн байна.

Үүний үр дүнд “Хүнсний хувьсгал”-ийг гардан гүйцэтгэж буй малчид, тариаланчид, ногоочид, баялаг бүтээгчид, үндэсний үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа өргөжин тэлж, зохих амжилтад хүрч чаджээ. Энэ бол төр, хувийн хэвшил гар нийлж ажилласны үр дүнд төдийгүй баялаг бүтээгчдийн нөр их хүч хөдөлмөр, хичээл зүтгэл, санал санаачилгын ач юм.

Тухайлбал, хүнсний салбарт нийт 24 хүнсний үйлдвэр шинээр ашиглалтад оржээ.

Мөн 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр ил талбайн хүнсний ногоо 30 хувиар, хүлэмжийн ногоо 27 хувиар, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 12 хувиар, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 6 орчим хувиар тус тус нэмэгдсэн.

Ялангуяа жимс жимсгэнэ, хүнсний ногооны нэр төрөл нэмэгдэж, түүхэндээ хамгийн өндөр хэмжээний ургац хураан авч, хүнсний ногооны дотоодын хангамж оны эцэс гэхэд 85 хувь хүртэл нэмэгдсэн байна.

Мөн 2023 оны эхний 11 сарын байдлаар махны экспорт эрс нэмэгдэж, 277 сая ам.долларын экспортын орлого олжээ. Үүний зэрэгцээ манай улсын хүнсний бүтээгдэхүүний импорт 12 хувиар буурсан сайхан үзүүлэлт гарав. Өөрөөр хэлбэл 1 тэрбум гаруй ам.доллараар гадаадаас хүнсний бүтээгдэхүүн худалдаж авдаг байсан манай улс 120 сая орчим ам.долларыг эх орондоо үлдээжээ.



## Нэг зорилгын төлөө төр, хувийн хэвшил хамтран ажиллах жишиг тогтоосон нь:

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд УИХ-ын дөрвөн байнгын хороо, ЕТГ-ын дэргэдэх Хүнсний төсөл, хөтөлбөрийн алба, Эрдэмтдийн зөвлөл, төрийн захиргааны 35 байгууллага, олон улсын байгууллагууд, “Хүнсний хувьсгал” төрийн бус байгууллага буюу хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэргэжлийн холбоодын нэгдэл, арилжааны 10 банк, хэвлэл мэдээллийн баг зэрэг өргөн бүрэлдэхүүнээр ажиллаж эхэлсэн.

Тогтоолыг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж буй Ерөнхийлөгчийн Тамгын газар 2023 он гарснаас хойш 1000 гаруй баялаг бүтээгчтэй уулзаж, хоёр удаагийн томоохон хурал зөвлөгөөн хийсэн. Мөн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, бодит шийдвэр гаргах зорилгоор 100 орчим үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, баялаг бүтээгч нарын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд 400 гаруй оролцогч бүхий танилцах долоон удаагийн бизнес аялал, төрийн 11 байгууллагатай хамтран найман удаагийн сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан юм.

Үүнээс гадна УИХ-ын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж буй төрийн байгууллагууд зургаан сар тутамд нэг удаа хуралдаж, үндэсний хөдөлгөөний үр дүн, хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл, санал солилцож байна.

Нэг зорилгын төлөө төр, хувийн хэвшил хамтран ажилладаг зөв жишгийг тогтоож чадсан нь “Хүнсний хувьсгал” хөдөлгөөний бас нэг түүхэн амжилт.





## Дараагийн “нүүдэл”

**Б**ид өнгөрсөн хугацаанд үр дүнтэй ажиллаж чадсан ч зорилгодоо хараахан хүрээгүй байна. Тиймээс гарсан амжилтдаа сэтгэл ханах бус, урам зориг аван илүү эрчтэй ажиллах нь чухал. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний дараагийн “нүүдэл” юу байх вэ? гэдгийг тодорхойлсон байна.

Өмнөх жилүүдээс илүү их үр дүнд хүрэхийн тулд өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн оновчтой бодлогуудаа үргэлжлүүлнэ гэдгийг бодлого тодорхойлогчид илэрхийлсэн. Тухайлбал улаан буудайны татаас, сүүний урамшуулал, хүнсний ногоочдын урамшуулал гээд бүгд үргэлжилнэ. Мөн баялаг бүтээгчдэд үзүүлэх хамгийн том дэмжлэг бага хүүтэй, урт хугацаатай зээлийг дахин олгохоос гадна олон улсын байгууллага, хандивлагч орнууд, бусад улс орнуудын хамтын ажиллагааны хүрээнд шинэ төсөл, зээл тусламжууд үзүүлэхээр ажиллаж байна.

Энэ онд “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд төрийн бодлогын төвлөрөх томоохон асуудал нь хүнсний чанар эрүүл ахуй гэдгийг онцоллоо. Хүнсний аюулгүй байдал гэдэг нь хүнсний хангамж, тогтвортой байдал, хүртгэмж, хэрэглээ \чанар эрүүл ахуй\ эдгээр үзүүлэлтийн цогцолбор юм. Хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд үр дүн гарч эхэлсэн тул үүнийг дагаад иргэдийн дунд хүнсний зөв хэрэглээг бий болгох ёстой гэж үзжээ.

*Сэтгүүлч Б.Урантуяа*

**Мэндчилгээ**

**М**онгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн салбарт ажиллаж, “Хүнсний хувьсгал”-ын түүхийг хамтдаа бүтээлцэж байгаа хүнс үйлдвэрлэгч, малчин, тариаланч, хэрэглэгч, сэтгүүлийн уншигч Та бүхний амгаланг айлтан мэндчилье.

Монгол Улсын Ерөнхийлөгч “Хүнс эрүүл бол хүн эрүүл” хэмээх зарчмын дор “Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, мал аж ахуй, газар тариалангаа эрчимжүүлэн хөгжүүлж, бүс нутагтаа органик хүнс экспортлогч улс болох” зорилт тавьсан билээ.

Улс орныхоо нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор “Халамжаас хөдөлмөрт, Олборлолтоос боловсруулалтад, Импортоос экспортод” шилжих суурь реформын хүрээнд “100 жил – 10 зорилт” хөгжлийн санаачилгыг дэвшүүлсний нэг нь энэхүү зорилт юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж байгаа “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн нь “хүнс” бол хувь хүний өдөр тутмын анхдагч хэрэгцээ боловч хүн амын эрүүл мэнд, ахуй соёл, үндэсний ондоошлын салшгүй хэсэг, улс орны эдийн засгийн хөдөлгөгч хүчний нэг, үндэсний аюулгүй байдлын чухал асуудал мөн болохыг харуулсан томоохон бодлого билээ.

Түүнчлэн, хэрэглэгчийн ширээн дээр байгаа хүнсийг бүтээхэд хөрс, ургамал, мал, тэдгээрийн эрүүл мэнд, цаг агаарын байдал, үйлдвэрийн хүчин чадал, логистик, техник хэрэгсэл, лаборатори, ур чадвар, хүний нөөц, зах зээл, эрчим хүч зэрэг маш олон салбарын хамтын үйл ажиллагаа, хүчин зүйл нөлөөлдөг бөгөөд хүнсний хэрэгцээгээ дотоодоосоо хангадаг байх нь өнөөдрийн бидний өмнө тулгарч байгаа сорилт бас хүнсний үйлдвэрлэлийн салбараа хөгжүүлэх боломж юм.

Ерөнхийлөгчийн тамгын газар “Хүнсний хувьсгал” хөдөлгөөнийг хэрэгжүүлэхээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, төрийн болон төрийн бус байгууллага, малчид тариаланчидтай тогтвортой хамтран ажиллаж байна.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх нийслэл болон орон нутгийн нийт 80 орчим үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцаад байна. Үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн явцад чамлахааргүй үр дүн гарч байгааг дурдахад таатай байна.

Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 36 дугаар тогтоол батлагдсанаар хууль эрхзүйн орчны өөрчлөлт, шинэчлэл хийгдэж, Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн болон хүнсний үйлдвэр, аж ахуй шинээр байгуулагдан, зах зээлд 200 орчим шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлсэн байна. Өнгөрсөн оны статистик мэдээгээр дотоодын өндөгний үйлдвэрлэл 7.9, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3.4, хүнсний ногооны үйлдвэрлэл төрлөөс хамаарч 7.7-20.9 хувиар, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.2 хувиар тус тус өсөж, импортын хүнсний бүтээгдэхүүний хэмжээ буурсан үзүүлэлт гарсан.

Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүрээнд 2024 оны есдүгээр сарын байдлаар нийт 1,192.8 тэрбум төгрөгийн зээлийг нийт 3113 аж ахуйн нэгж, иргэнд олгожээ.



Цаашид үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэхийн тулд уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, дасан зохицох, байгалийн нөөцийг зохистой ашиглах, ногоон хөгжлийн үзэл санааг хэрэгжүүлэх дорвитой алхмуудыг хийж, Шинэ хоршоо-Чинээлэг малчин хөдөлгөөн, Атрын IV аян болон бусад холбогдох томоохон хөдөлгөөн, арга хэмжээтэй харилцан хамаарал, уялдаа холбоог ханган бүтээмж, үр ашгийг чухалчлан ажиллах шаардлагатай.

Төрийн зүгээс татвар, зээлийн бодлогын цогц шинэчлэлд анхаарч, баялаг бүтээгч, дотоодын үйлдвэрлэгчдээ дэмжих, хамгаалах, хөгжүүлэхэд чиглэгдэх ёстой.

“Хүнсний хувьсгал”-ыг эрчимжүүлэн өрнүүлснээр төрийн бодлогын болон хөрөнгө оруулалтын үр өгөөж нэмэгдэж, хүнсний нийлүүлэлтийн сүлжээний аюулгүй, тогтвортой байдал хангагдан, хүн амаа дотооддоо үйлдвэрлэсэн шим тэжээллэг, аюулгүй хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангаж, хүнс экспортлогч орон болно гэдэгт итгэлтэй байна.

Энэ үр дүнд хүрэхэд хүнсний сүлжээнд оролцогч талуудын үйл ажиллагаа, идэвх чармайлтаас гадна бүх нийтийн оролцоо, ялангуяа хэрэглэгч иргэн бүрийн үндэсний үйлдвэрлэлээ дэмжих хандлага бодитой хувь нэмэр оруулна.

“Айлаас эрэхээр авдраа уудал” гэсэн ардын сайхан үг бий. Монголоо гэсэн зүрх сэтгэлтэй хүн бүр “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, хамтран ажиллахын зэрэгцээ эх орондоо үйлдвэрлэсэн хоол хүнс, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авдаг хэрэглэгч байхыг уриалж байна.

Эх орондоо “хүнсний хувьсгал”-ыг хэрэгжүүлж

Эрүүл Монгол хүнийг төлөвшүүлэх эрхэм үйлсийн төлөө хамтдаа зүтгэцгээе.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ГОМБОЖАВЫН  
ЗАНДАНШАТАР



# Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн дэлхийн зах зээлд гарахад төрийн тэргүүний харилцан айлчлалууд чухал үүрэг гүйцэтгэнэ

2024.10.10- 2024.10.13

**Монгол Улсын Ерөнхийлөгч  
Ухнаагийн Хүрэлсүх Туркменистан  
Улсын Ерөнхийлөгч Сердар  
Бердымухамедов-ын урилгаар тус  
улсад төрийн айлчлал хийлээ.**

Энэ удаагийн айлчлал нь Монгол Улс,  
Туркменистан Улсын хооронд 1992 оны дөрөв  
дүгээр сарын 23-ны өдөр дипломат харилцаа  
тогтоосноос хойш Монгол Улсын төрийн  
тэргүүний түвшинд хэрэгжиж буй анхны  
төрийн айлчлал гэдгээрээ онцлог юм.



Туркменистан Улс - 2024.10.12



**Х**өдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн  
хөгжүүлэх, хоёр талын худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх  
хүрээнд хөдөө аж ахуй, мал эмнэлэг, мал аж ахуйн чиглэлээр  
хамтран ажиллах тухай баримт бичгүүдийг байгуулж, Монгол,  
Туркменистаны зах зээлд хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн гаралтай  
бараа бүтээгдэхүүнийг харилцан нийлүүлэхээр тохиролцлоо.

**–“МАЛ ЭМНЭЛЭГ, МАЛ АЖ АХУЙН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ  
ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН ЯАМ, ТУРКМЕНИСТАН УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН  
ЯАМ ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”**–т Монгол Улсын Хөдөө аж ахуй,  
хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбаагийн Энхбаяр, Туркменистан Улсын  
Хөдөө, аж ахуйн сайд Чарыяр Четиев нар гарын үсэг зурав.

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд талууд өөрийн улсын нутаг дэвсгэрт  
мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний худалдааг хөнгөвчлөх, малын  
өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, малын эрүүл мэндийг хамгаалах,  
мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх чиглэлээр мал эмнэлэг, мал аж ахуйн  
салбарт хамтран ажиллахаас гадна хоёр улсын холбогдох байгууллагууд  
хооронд мал эмнэлгийн шинжлэх ухаан, өвчний тандалт, хяналтын арга  
хэмжээний талаар мэдээлэл, туршлага солилцох боломжийг бүрдүүлж  
буй юм. Түүнчлэн талууд мал аж ахуйн мэргэжилтнүүд, малын эмч,  
эрдэмтдийн уулзалт, мэдлэг солилцох сургалт, чадавхыг бэхжүүлэхэд  
харилцан бие биедээ дэмжлэг үзүүлж ажиллахаа илэрхийлсэн нь хоёр

улсын мал, эмнэлгийн салбарын хамтын ажиллагааг эхлүүлэхэд чухал ач  
холбогдолтой суурь баримт бичиг болж байна.

**–“ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ЯАМ, ТУРКМЕНИСТАН УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ  
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”**–т Монгол Улсын Хөдөө аж ахуй, хөнгөн  
үйлдвэрийн сайд Жадамбаагийн Энхбаяр, Туркменистан Улсын Хөдөө,  
аж ахуйн сайд Чарыяр Четиев нар гарын үсэг зурав.

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд талууд хөдөө аж ахуйг цахимжуулах,  
орчин үеийн инновац, технологийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд  
нэвтрүүлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах  
хамтарсан үйлдвэр байгуулах, мал аж ахуй, мал аж ахуйн үйлдвэрлэл,  
органик газар тариаланг хөгжүүлэх, газар тариалан, тэр дундаа хүнсний  
аж ахуй, жимс, жимсгэний салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх  
гэсэн үндсэн чиглэлүүдээр хамтран ажиллахаар тохиролцлоо.

Монгол Улс нь Төв азийн бүс нутагт хөдөө аж ахуйн салбартаа  
тэргүүлэх байр суурь эзэлдэг, уламжлалт хөдөө, мал аж ахуйтай  
Туркменистан Улстай энэ салбарт идэвхтэй хамтран ажиллаж,  
туршлага солилцох нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны  
хөтөлбөрийн хүрээнд батлагдсан бүсчилсэн хөгжлийн бодлоготой  
уялдах бөгөөд ийнхүү тус хэлэлцээр нь цаашид хоёр улс хөдөө аж  
ахуйн салбарын хамтын ажиллагаагаа амжилттай хөгжүүлэх боломжийг  
бүрдүүлсэн суурь баримт бичиг нь болж байна.





Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Туркменистан Улсад хийж буй төрийн айлчлалынхаа хүрээнд “Цаг үе, соёл иргэншлийн хэлхээ холбоо-Энх тайван, хөгжлийн үндэс суурь” олон улсын форумд хүндэт зочноор оролцож, нээлтийн үйл ажиллагаанд үг хэллээ.



Энэхүү төрийн айлчлалд багтсан үндэсний үйлдвэрлэгч, баялаг бүтээгчдийн төлөөлөл “МОНГОЛ-ТУРКМЕНИСТАН БИЗНЕС ФОРУМ”-д оролцлоо.



Туркменистан Улс. 2024.10.12



Монгол Улсын үндэсний үйлдвэрлэгчид Туркмен үндэсний хивсний музей, нэхмэлийн үйлдвэр болон аж үйлдвэрийн бүстэй танилцаж, туршлага судаллаа.



2024.09.30-2024.10.01


Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгч, Намын Ерөнхий нарийн бичгийн дарга То Лам Монгол Улсад төрийн айлчлал хийлээ.



## Монгол Улс, БНСВУ-ын хооронд Иж бүрэн түншлэлийн харилцаа тогтоох тухай Хамтарсан тунхаглал гаргалаа

Төрийн тэргүүн нар 2022 онд байгуулсан “Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон БНСВУ-ын Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийг шинэчлэхээр тохиролцов.

Талууд хөдөө аж ахуйн салбарт баримталж буй хөгжлийн бодлого, цаашид авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээнүүдийн талаарх мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, хөдөө аж ахуйн салбар дахь дэвшилтэт технологийг судалж, хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлд харилцан дэмжлэг үзүүлэхээ илэрхийлэв.



Төрийн тэргүүн нар зам тээвэр, ложистикийн саад бэрхшээлийг шийдвэрлэх, хоёр улсын хооронд авто зам, төмөр зам, агаарын тээвэр, далайн тээврийн салбарт байгуулсан баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллахаар тохиров.

Энэ удаагийн айлчлал Монгол Улсын

Ерөнхийлөгчийн 2023 онд Вьетнам Улсад хийсэн төрийн айлчлалын хариу айлчлал бөгөөд хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд болсноороо онцлогтой байлаа.



2024.09.21

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх АНУ-ын Нью-Йорк хотноо НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 79 дүгээр чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд оролцлоо.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн энэ жилийн чуулганы Ерөнхий санал шүүмжлэлийг “Хэнийг ч үл орхигдуулах: одоо болон ирээдүй хойч үеийнхний төлөө хамтдаа энх тайван, тогтвортой хөгжил, хүний эрхэм чанарыг дээшлүүлэх нь” сэдвээр зохион байгуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Ирээдүйн асуудлаарх дээд түвшний уулзалт, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 79 дүгээр чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд тус тус оролцож, олон улсын харилцааны тулгамдсан асуудлаар Монгол Улсын байр суурь, төр, засгаас хэрэгжүүлж буй гадаад бодлогын зорилт, тэргүүлэх чиглэлийг танилцуулж үг хэллээ.

Мөн НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга болон гишүүн зарим улсын төр, засгийн тэргүүнтэй хоёр талын уулзалт хийж харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон юм.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 79 дүгээр чуулганд 140 орчим улс орон төр, засгийн тэргүүний түвшинд оролцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх 2021 оноос жил бүр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Ерөнхий санал шүүмжлэлд оролцож байна.

2024.09.03



Халх голын байлдааны 85 жилийн ойг тэмдэглэх хүрээнд Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Владимир Владимирович Путин Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ.

Айлчлалын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин нар ганцаарчилсан уулзалт болон албан ёсны хэлэлцээ хийж, үр дүнгийн талаар мэдээлэл өглөө.

Мөн талууд эрчим хүч, газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх, байгаль орчин зэрэг салбарт хамтран ажиллах тухай баримт бичгүүдэд гарын үсэг зурлаа.

Энэхүү хэлэлцээрийн үр дүнд Монгол Улсаас Евразийн эдийн засгийн холбооны гишүүн орнуудад гаргах мал аж ахуйн гаралтай 375 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн импортын татвараас бүрэн чөлөөлөгдөх боллоо.

Энэ нь манай хөдөө аж ахуйн салбар болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд ихээхэн дэмжлэг үзүүлэх төдийгүй худалдаа, хөрөнгө оруулалт, бизнесийн орчинд шинэ боломжуудыг нээх юм.

Ерөнхийлөгч В.В.Путины албан ёсны айлчлал найрсаг харилцаа, хамтын ажиллагааг улам бүр бататган бэхжүүлж, эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, ялангуяа түлш, эрчим хүч, зам тээвэр, байгаль орчин, соёл, боловсрол, эрүүл мэнд, хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг улам хөгжүүлэхэд чухал түлхэц боллоо.

2024. 08.20




Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар Бүгд Найрамдах Словени Улсын Ерөнхийлөгч Др.Нагаша Пириц Мусар төрийн айлчлал хийлээ.

Айлчлалын үеэр хоёр улсын төрийн тэргүүн “Монгол, Словенийн Хамтарсан тунхаглал”-д гарын үсэг зурлаа.



2024.08.02



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар Швейцарын Холбооны Улсын Ерөнхийлөгч Виола Амхерд анх удаа төрийн айлчлал хийв.

Монгол Улс, Швейцарын Холбооны Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд хэрэгжсэн төрийн айлчлалын үеэр “Монгол-Швейцарын Хамтарсан тунхаглал”, “Ардчилсан засаглалын асуудлаарх Харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурсан нь хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, ардчилсан засаглалыг бэхжүүлэх хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх чухал ач холбогдолтой болов.



2024.07.09



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар Бутаны Хаант Улсын Цог Жавхлант Хаан Жигмэ Гэсэр Намжил Ванчукийн анхны төрийн айлчлал хийлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, гэргий Лувсандоржийн Болорцэцэгийн хамт Бутаны Хаант Улсын Цог Жавхлант Хаан Жигмэ Гэсэр Намжил Ванчук, Хатан Жэцүн Пэма Ванчук нарыг Д.Сүхбаатарын талбайд албан ёсоор угтан авсан юм.

Айлчлалын хүрээнд Төрийн тэргүүн нар Хамтарсан мэдэгдэл гаргаж, харилцаа, хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар баяжуулах, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, соёл, боловсрол, аялал жуулчлал зэрэг тэргүүлэх салбарт бодит ахиц гаргахаар тохиролцсон.





2024.07.04



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Бүгд Найрамдах Казахстан Улсын Астана хотноо Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ)-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд ажиглагчаар оролцож, үг хэллээ.

Тэрбээр, Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, олон тулгуурт, бие даасан гадаад бодлогыг тууштай хэрэгжүүлж байгаа болон НҮБ-ын гишүүн бүх улстай дипломат харилцаа тогтоосныг тэмдэглэв.


Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Касым-Жомарт Токаев-тай уулзав.

Хоёр улсын төрийн тэргүүн хоёр орны найрсаг харилцааг бататган бэхжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар баяжуулах хүрээнд дээд, өндөр түвшний айлчлал хэрэгжүүлэх, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, тээвэр, ложистик зэрэг тэргүүлэх салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхээр тогтлоо.



Мөн энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррештэй уулзлаа.

Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх НҮБ-тай хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаандаа тэргүүлэх ач холбогдол өгч, тус байгууллагын хүрээнд дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахыг зорьж буйг онцлон тэмдэглэлээ.




Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Киргиз Улсын Ерөнхийлөгч Садыр Жапаров-тай уулзав.

Цаашид уламжлалт найрсаг харилцаагаа гүнзгийрүүлэн бататгах хүрээнд батлан хамгаалах, худалдаа, эдийн засаг, боловсрол, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, тээвэр, ложистик зэрэг салбарт идэвхтэй, нягт хамтран ажиллахаа илэрхийлэв.

Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг Киргиз Улсын “Ногоон өв” санаачилгатай уялдуулан Киргизийн жимс, жимсгэний модны суулгацыг Монголд нутагшуулах, Эрдэнэт хотноо “Монгол, Киргизийн найрамдлын төгөл” цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил идэвхтэй өрнөж буйг талууд сайшаалаа.

2024.06.23



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Бүгд Найрамдах Узбекистан Улсын Ерөнхийлөгч Шавкат Мирзиёевийн урилгаар тус улсад төрийн айлчлал хийв.

Талууд цаашид харилцан ашигтай эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд уул уурхай, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, тээвэр, ложистик, аялал жуулчлал, боловсрол, соёл, эрүүл мэнд зэрэг салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлэхийн төлөө буйгаа нотлов



Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын нөөц, бололцоонд тулгуурлан хоёр улсын харилцааны бэлгэ тэмдэг болохуйц хамтарсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр талууд санал нэгдэж, Ажлын хэсэг байгуулахаар болов.

Айлчлалын хүрээнд Ташкент хотноо зохион байгуулж буй “Монгол-Узбекистаны бизнес форум”-д хоёр улсын 300 гаруй аж ахуйн нэгж оролцож байгааг сайшааж, цаашид хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн үзэсгэлэн, худалдааг хамтран зохион байгуулахаар тогтов.


2024.06.01

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар БНБУ-ын Ерөнхийлөгч А.Г.Лукашенко Монгол Улсад төрийн айлчлал хийлээ.

Төрийн айлчлалын үеэр хоёр улсын Төрийн тэргүүн “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ”-нд гарын үсэг зурав.

Тус гэрээ нь уламжлалт найрсаг харилцааны үндсийг тодорхойлох чухал баримт бичиг бөгөөд хамтын ажиллагаа шинэ шатанд гарч, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл болон бусад салбар дахь харилцаа өргөжин хөгжих юм.

Баримт бичигт хөдөө аж ахуйн салбарт өмнө байгуулсан баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, мал аж ахуй, мал эмнэлэг, газар тариалангийн чиглэлээр ойрын хугацаанд авч хэрэгжүүлэх ажлын талаар тусгажээ.



2024.06.11



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Ерөнхийлөгч Тонглун Сисүлит Монгол Улсад төрийн айлчлал хийв.

Төрийн тэргүүн нар Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2023 онд Лаос Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр ярьж тохирсон санал, санаачилгууд бодит ажил хэрэг болж буйг сайшаасан юм.

Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хувьд энэ сул талаа давуу тал болгон ашиглаж, харилцааг худалдаа, эдийн засгийн агуулгаар баяжуулан, улс төр, батлан хамгаалах, зам тээвэр, хөдөө аж ахуй, боловсрол, соёл, эрүүл мэнд зэрэг салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэхийн төлөө байгааг нотлов.

Төрийн тэргүүн нар өнгөрсөн онд “Мал эмнэлэг, мал амьтны хорио цээрийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулсан юм.

Үүний мөрөөр “Монгол Улсаас Лаос Улс руу хөлдөөсөн хонь, ямаа, үхэр, адууны мах экспортлох олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ”-г тохирч буй нь хүнс, хөдөө аж ахуй, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулна гэдэгт санал нэгдлээ.





2024.10.28



## Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Касым-Жомарт Кемелевич Токаев 2024 оны 10 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд төрийн айлчлал хийлээ.

Айлчлалын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Касым-Жомарт Токаев нар албан ёсны хэлэлцээ хийв.

“ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ БОЛОН МАЛ ЭМНЭЛЭГ, ХОРИО ЦЭЭРИЙН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ, БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ”-г



хүнсний бүтээгдэхүүний мал эмнэлгийн гэрчилгээний тоог нэмэгдүүлж, энэ салбарт мэдээлэл солилцохоор тохиролцлоо. Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээгээр мал эмнэлэг, хорио цээр, ариун цэврийн шаардлагыг харилцан тохиролцох замаар мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний худалдаанд дэмжлэг үзүүлэх боломж бүрдлээ.

Талууд өнгөрсөн 30 гаруй жилийн харилцааны ололт, амжилтыг дүгнэн хэлэлцэж, уламжлалт найрсаг харилцааг шинэ шатанд гаргах, хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар баяжуулах болон олон улс, бүс нутгийн тавцан дахь хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх талаар санал солилцлоо.

Ерөнхийлөгч К.Токаевын энэ удаагийн төрийн айлчлал нь Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн тэргүүний түвшинд 2008 онд хийсэн айлчлалаас хойш 16 жилийн дараа болж байна.

Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс 1992 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр дипломат харилцаа тогтоожээ.


Мөн ондоо манай улс Алматы хотод, Казахстан Улс 1997 онд Улаанбаатар хотод Элчин сайдын яамаа нээсэн. Манай улсын Элчин сайдын яам одоо Астана хотноо байрлаж байна.



Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбын Энхбаяр, Бүгд Найрамдах Казахстан Улсын Хөдөө аж ахуйн сайд Айдарбек Сапаров,

- Арьс шир, ноосны боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, талуудын инженер, техникийн ажилтан, төрийн болон аж ахуйн нэгжүүдийн холбогдох мэргэжилтнүүдийг бэлтгэх болон арьс шир, ноос гүн боловсруулахад хөрөнгө оруулалт татах, технологи нутагшуулах, нэвтрүүлэх чиглэлээр харилцан туршлага солилцож, хамтарч ажиллана. Малын арьс шир, ноос боловсруулах хяналтын тогтолцоо, стандарт, лабораторийн байгууламжийг хөгжүүлэх, боловсронгуй болгоход харилцан дэмжлэг үзүүлэхээр тохиролцлоо. Цаашид хоёр улсын харилцааны бэлгэ тэмдэг болохуйц хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой юм.

- Мал эмнэлэг, хорио цээрийн асуудал хариуцсан байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, нэгдсэн мэдээллийн систем үүсгэх,





Монгол Улсын Ерөнхийлөгчийн  
Гадаад бодлогын зөвлөх  
**Э.Одбаяр:**

**Ерөнхийлөгчийн  
санаачилга дэлхий  
дахинд тулгамдаж буй  
асуудлын шийдэлд  
хувь нэмэр оруулна**

**М**онгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачлан хэрэгжүүлж буй үндэсний хөдөлгөөнүүдийг олон улсын байгууллагууд болоод дэлхийн улс орнууд хэрхэн хүлээн авч, хамтран ажиллаж байгаа талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх Э.Одбаяртай ярилцлаа.

➤ **Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан үндэсний хөдөлгөөнүүдийг олон улсад хэрхэн хүлээн авч байна вэ?**

- Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх хөрс, хүнс, хүнээ эрүүл байлгах зорилготой, харилцан уялдаа холбоотой гурван хөдөлгөөн санаачилсан. Энэхүү “Тэрбум мод”, “Хүнсний хувьсгал”, “Эрүүл монгол хүн” хөдөлгөөнүүд хэрэгжиж буй гурван жилийн хугацаанд олон улсын хэмжээнд Монгол Улс илүү эерэг дүр төрхөөр танигдаж байна. Тухайлбал, НҮБ-ын индэр дээр Монгол Улсын Ерөнхийлөгч дээрх асуудлыг ярьж танилцуулсан. Мөн бусад улс орнуудтай хийж буй төрийн айлчлалынхаа хүрээнд харилцан ашигтай хамтын ажиллагааг эхлүүлж байгаа учраас бүс нутгийн хэмжээнээс давж, олон улсын хэмжээнд улс орнуудын дэмжлэгийг авч чадаж байгаа.

➤ **Ямар төрлийн дэмжлэгүүд үзүүлж байна вэ?**

- Олон улсын байгууллага, улс орнууд манай улстай хамтран төсөл хэрэгжүүлж байгаагаас гадна амжилттай хэрэгжсэн, үр дүнтэй туршлагаудаасаа хуваалцаж байна. Тухайлбал, Туркменистан улс гэхэд цөл дунд байдаг. Гэсэн хэдий ч нийслэл хот Ашхабадаа ногоон хот болгож чадсан. Иймд Туркменистан Улс усжуулалтын системээс эхлээд цөлд мод тарих туршлагаасаа хуваалцахад бэлэн байгаагаа илэрхийлсэн. Үүнээс гадна Ерөнхийлөгчийн санаачилгууд амжилттай хэрэгжих нь зөвхөн манай улсад бус олон улсын түвшинд ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, эдгээр хөдөлгөөнүүдээр дамжуулан дэлхий нийтэд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлт, хөрсний доройтол зэрэг асуудлуудыг шийдэхэд Монгол Улс тодорхой хувь нэмэр оруулж байна гэсэн үг. Бид бүс нутгийнхаа хэмжээнд өөрсдийн хөрш, гуравдагч хөршүүд, дэмжигч орнуудтай хамтран энэ үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаагаараа



онцлог. Сая гэхэд НҮБ-ын найм дахь Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн манай улсад айлчилж, “Чингис хаан” одонгоор шагнуулахдаа “Дэлхийн улс орнуудын хил хязгаар улам бүдгэрч, уур амьсгалын өөрчлөлт гэдэг хүн бүрийн өмнө тулгамдсан асуудал болсон. Иймд улс орнууд хил дотроо үйл ажиллагаа явуулах бус нэгдэж, олон улсын хэмжээний түншлэл бий болгон, байгаль орчны асуудалд анхаарах ёстой. Энэ бол хүн төрөлхтөн орших уу, эс орших уу гэдгийг шийдэх асуудал” хэмээн хэлсэн. Тиймээс бидний зорьж буй ажил дэлхий нийтийн зорьж буй ажилтай нэг учир харилцан ашигтай байдлаар хамтран ажиллаж байгаа юм.

#### ► “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд яривал?

- Хүнсний хангамж, аюулгүй байдал гэдэг зөвхөн манай улсад бус дэлхий дахинд тулгамдаж буй асуудал. Энэ нь олон янзын бодлогоос улбаатай. Шууд нэг улсын буруу гэхээсээ илүү эдийн засгийн системтэй холбоотой юм. Мөн хүнсний хомсдол, өлсгөлөн, хүнсний хямралыг эрчимжүүлж буй хамгийн том хүчин зүйлс нь дэлхий даяар дэгдэж дуй зэвсэгт мөргөлдөөнүүд болон сүүлийн 10-аад жил олон улсын анхаарлын төвд байгаа уур амьсгалын өөрчлөлт юм. Иймд бид нэн тэргүүнд дэлхийн дахинд тохиолдож буй гамшгаас хамгаалж эх орныхоо хөрсөнд тарьж, ургуулсан, эрүүл хүнсээр өөрсдийгөө хангах, урьдчилан сэргийлэх, цаашлаад бүс нутагтаа экспортлогч орон болж хүн төрөлхтний өмнө тулгарч буй хүнсний хомсдолын асуудлыг шийдэхэд хувь нэмрээ оруулах ёстой гэсэн бодлого юм. Үүнийг дотооддоо хэдэн компаниудыг дэмжээд, хуралдаад шийдчих асуудал биш. Олон улсын хэмжээний бодлогын уялдаа холбоо, дэмжлэг хэрэг болно. Ингэснээр манай улсад үйлдвэрлэлийн механизм, аж үйлдвэрлэлийн бүтэц, систем, тоног төхөөрөмж, технологи, инновац нэвтрэнэ. Мэдээж энэ нь бодит ажил болоод хувийн хэвشلүүд хамгийн сүүлийн үеийн, байгаль орчинд ээлтэй техник технологийг нэвтрүүлсээр байна.

#### ► Төрийн тэргүүний айлчлалуудын хүрээнд уг бодлогыг дэмжсэн ямар ажил хийв?

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалуудын хүрээнд хэд хэдэн өөрчлөлт бий болсон. Бизнес бүрэлдэхүүнийг авч явахдаа зааланд хуралдаад, зургаа авхуулахаас илүү түрүүлж багаа илгээх, эсвэл түрүүлж тухайн улсын багийг ирүүлэх, эртнээс ямар чиглэлээр хамтарч ажиллах боломж байгааг судлан, холбоо тогтоох, баг бүрэлдэхүүндээ зөвлөмж өгөх,

мэдээллээр хангахад анхаарч байна. Мөн айлчлал бүрийн үеэр Худалдаа, аж үйлдвэрийн танхим хоорондын хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурдаг.

#### ► Ямар хувийн хэвشلүүд төрийн тэргүүний айлчлалд багтдаг вэ?

- Айлчлалын хүрээнд төр, засгийн бодлого үйл ажиллагаатай нийцэх, үрдүнтэй хамтын ажиллагаа цогцлоох боломжтой аж ахуйн нэгжүүд, аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг харилцан хөрөнгө оруулах боломж бүхий компаниуд, бусад сонирхсон аж ахуйн нэгжүүд болон баялаг бүтээгчдийг дэмжиж ажиллаж байна.

#### ► Өөр ямар өөрчлөлт гарсан бэ?

- Бас нэг том өөрчлөлт нь бизнесийн баг бүрэлдэхүүнээ чадавхжуулах ажил хийдэг болсон. Уулзалт, хурал хийхээс гадна тухайн бизнес эрхлэгчийн сонирхсон болон адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцуулах, тоног төхөөрөмжийг нь үзүүлэх, бараа бүтээгдэхүүнтэй нь танилцуулах, туршлага судлах, томоохон зах, худалдааны төвүүдтэй танилцуулах зэрэг ажлуудыг хийж эхэлсэн. Үр дүнд нь үйлдвэрлэгчид өөрсдийн хийж байгаа бүтээгдэхүүнтэй харьцуулан, суралцаж, дэлхий нийтэд ямар бараа бүтээгдэхүүнийг сонирхож, ямар стандартын дагуу үйлдвэрлэж, хадгалж, тээвэрлэдэг талаар өргөн мэдлэгтэй болж чадсан. Монгол Улсын эдийн засагт үнэтэй хувь нэмэр оруулж буй татвар төлөгч, баялаг бүтээгчдэдээ дарамт учруулах бус харин дэмжих ёстой гэсэн бодлогоор Монгол Улсын Ерөнхийлөгч айлчлалуудынхаа хүрээнд эдгээр ажлыг хийж байна.

#### ► Монгол Улсын Ерөнхийлөгч харилцан айлчлалууд их хийж байна. Үүний онцлог, ач холбогдол нь юу вэ?

Ерөнхийлөгчийн айлчлал, гадаад бодлогын хүрээнд хоёр том зарчмын өөрчлөлт гарсан. Эхнийх нь, бид өөрсдөө очих гэхээсээ илүү харилцан айлчилдаг болсон. Мөн зээл, тусламж гүйх бус харилцан ашигтай хамтын ажиллагааг эхлүүлж байна. Хоёр дахь нь, “Дэлхийг монголд” буюу айлчлалыг Монгол руу гэсэн бодлого амжилттай хэрэгжиж эхэллээ. Монгол Улсын Ерөнхийлөгч Зүүн өмнөд Ази руу чиглэсэн гадаад бодлогоо идэвхжүүлэх хүрээнд 2023 онд БНСВУ, БНАЛАУ руу айлчлал хийж байсан бол энэ жил тэдгээр улсын төрийн тэргүүн нар манай улсад хариу айлчлал хийж хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр хамтран ажиллах тухай гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурсан. Мөн Бутаны Хаант Улсын Цог Жавхланта Хаан Жигмэ Гэсэр Намжил Ванчук хатны хамтаар манай улсад түүхэн айлчлал хийсэн. Үүнээс гадна Төв Ази руу чиглэсэн гадаад бодлогыг идэвхжүүлэх ажил эрчимтэй өрнөж байна. Ялангуяа, энэ бүс нутгийн улсуудтай хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах боломж их бий. Сүүн бүтээгдэхүүний хэрэглээ, хоол, хүнсний соёл ойролцоо тул монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг экспортлох шинэ зах зээл гэж харж байна.

Ярилцсан: Б.Урантуяа



# “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд

**Т**өлөвлөсөн ажил  
бүхэн эзэн биетэй  
байж, хэн, ямар  
ажил хийж, ямар үр дүн  
гаргах нь тодорхой байх  
ёстой. Энэ бол төрийн  
бодлого амжилттай  
хэрэгжих гол үндэс.



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**



**90** арга хэмжээ



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН  
ЭРДЭМТДИЙН ЗӨВЛӨЛ**



**4** БАЙНГЫН  
ХОРОО



**ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР  
ХҮНСНИЙ ТӨСӨЛ,  
ХӨТӨЛБӨРИЙН АЛБА**



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН  
ХОЛБООДЫН НЭГДЭЛ  
“ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ” ТББ**



# ХЭН, ХЭРХЭН АЖИЛЛАЖ БАЙНА ВЭ?

# 35

**ТӨР, ЗАХИРГААНЫ  
БАЙГУУЛЛАГУУД**

Засгийн газрын  
63 дугаар тогтоол



# 10

**СИСТЕМИЙН БАНК**

**БАГА ХҮҮТЭЙ  
УРТ ХУГАЦААТАЙ ЗЭЭЛ**

5% - Эргэлтийн хөрөнгийн  
6% - Хөрөнгө оруулалтын

**ТАТААС 13%**

**ОЛОН УЛСЫН  
БАЙГУУЛЛАГУУД**

## ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ ЦУВРАЛ КОНТЕНТ

- Телевиз Соён гэгээрүүлэх
- Фм радио /36-р тогтоолын К заалт/
- Сайт
- Сэтгүүл
- Сошиал медиа



“Хүнсний хувьсгал”  
үндэсний хөдөлгөөн  
хэрэгжих явцад үр дүнгүй  
ажилласан, ахиц дэвшил  
гаргаагүй байгууллагын  
удирдлага, албан  
тушаалтанд хариуцлага  
тооцно гэдгийг хатуу  
анхааруулж байв.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн  
Ахлах зөвлөх  
**Н.Хүрэлбаатар:**

## Пестицид хэрэглэх стандарт мөрддөггүй нь байгаль орчныг бохирдуулахаас гадна олон төрлийн өвчин, хавдар үүсгэдэг

**“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн хэрэгжсэн хоёр жил гаруйн хугацаанд хүнсний хангамжийн асуудлыг шийдэх томоохон ажлууд хийгдэж, чамлахааргүй үр дүн гарсан. Иймд ЕТГ-ын зүгээс дараагийн жилүүдэд хүнсний аюулгүй байдалд онцгой анхаарч ажиллахаар төлөвлөжээ. Энэ талаар Ерөнхийлөгчийн Ахлах зөвлөх, Анагаах ухааны Доктор PhD, Профессор Н.Хүрэлбаатартай ярилцлаа.**

**» Бидний урилгыг хүлээн авч, цаг гарган ярилцаж байгаа танд баярлалаа. Таны хувьд ажлаа хүлээн авмагц иргэдийн эрүүл мэнд, тэр дундаа хүнсний аюулгүй байдалд онцгой анхаарал хандуулж байгааг анзаарлаа. Энэ тухай ярилцлагаа эхлэх үү?**

Энэ асуудлын хувьд аль эрт төлөвлөгдөөд, үйл ажиллагаа нь үргэлжлээд явж байгаа ажил юм. Ер нь хүн эрүүл байх эсэх нь амьдралын хэв маяг, амьдарч буй орчин нөхцөл, хоол хүнс, эрүүл мэндээ хамгаалах мэдлэг чадвар, цаашилбал төр засгийн бодлого, үйл ажиллагаа гэх мэт олон зүйлээс хамаардаг.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж байгаа “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл монгол хүн”, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, нуур цөөрөм, гол усаа хамгаалах зэрэг олон ажил нь хүн, амьтан оршин байх ээлтэй орчин бүрдүүлэх, иргэд эрүүл чийрэг, чанартай амьдрах нөхцөл, боломжийг бий болгох зорилготой юм.

Одоо бидний ярьж байгаа эх орондоо эрүүл, аюулгүй хүнс үйлдвэрлэх, хангах асуудал нь ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, өөрөөр хэлбэл манай улсын иргэн бүр эрүүл, чанартай амьдрах үндсийн үндэс болох юм. Товчхондоо эрүүл хүнс, амьдралын зөв хэв маяг бол эрүүл энх байхын үндэс мөн.

Монголчууд бид стандарт шаардлага хангасан эрүүл

аюулгүй хоол, хүнс хэрэглэж байж, эрүүл чийрэг, чанартай сайн сайхан амьдрах нь хэнд ч ойлгомжтой асуудал юм. Иймээс л улсын Ерөнхийлөгчөөсөө эхлүүлээд бид бүгд үүнийг хэрэгжүүлж, бодит үр дүн гаргахын төлөө ажиллаж байна даа.

**» Цаашид ямар арга хэмжээ авах вэ. Олон улс энэ асуудалтай хэрхэн тэмцэж байна вэ?**

Монголчууд бид өөрсдийгөө хүнс, ногоогоор бүрэн хангахын зэрэгцээ хүнс үйлдвэрлэх, жимс, ногоо тарьж ургуулах, хадгалах, түгээх явцын эрүүл ахуйн стандартыг мөрдөж ажиллах шаардлагатай юм.

Түүнээс гадна, импортын жимс, ногоо, хүнсний бүтээгдхүүний чанар, аюулгүй байдалд бүрэн хяналт тавьж, иргэдийг аюулгүй, чанартай хүнсээр хангах нь хүн амын эрүүл мэндийг хамгаалахад ямар чухал ач холбогдолтой болохыг эрдэмтдийн судалгааны үр дүн харуулж байна.

Эрүүл аюулгүй хүнс болохыг илтгэдэг гол үзүүлэлт бол хүнсэнд байх пестицидийн хэмжээ юм. Пестицид гэдэг нь ургамлын өвчин, хортон шавж, өт авгалдай, нян, мөөгөнцөр, амьтдын паразит, мэрэгчидтэй тэмцэхэд хөдөө аж ахуй, газар тариалан, ахуйн зориулалтаар хэрэглэдэг химийн бодис юм.

Дэлхийн даяар 6000 нэр төрлийн 100 гаруй сая тонн пестицид үйлдвэрлэгдэж байгаа бөгөөд пестицидийн хэрэглээ өдрөөс өдөрт өсч, хяналт алдагдаж эхэлсэн байна.

Пестицидийн хордлогоос шалтгаалж хүний эрүүл мэндэд ноцтой эрсдэл үүсгэдэг болохыг дэлхийн эрдэмтэд тогтоосон. Тухайлбал давсаг, тархи, хөх, өндгөвч, бамбай булчирхайн хавдрын шалтгаан болдог төдийгүй харшил, чихрийн шижин, жирэмсний үеийн хордлого болон урагт сөрөг нөлөө үзүүлэх гэх мэт олон өвчлөл үүсгэж байна.

Түүнчлэн дэлхий даяар 860 сая хүн газар тариалан эрхэлж байгаагаас 44 хувь буюу 385 сая хүн пестицидийн почмог хордлогод өртөж байгаа тухай статистик мэдээлэл ч байна. Үүнээс харахад пестицидийн хэрэглээ манай улсын төдийгүй дэлхийн нийтийн тулгамдсан асуудал болж



байна. Хүнсний аюулгүй байдал гэдэг нь үндэсний аюулгүй байдлын нэг томоохон асуудал юм.

Иймээс манай улс пестицидийн хэрэглээний стандартыг чанд мөрдөж, хяналтыг сайжруулж, иргэдээ аюулгүй хүнсээр хангах нь чухал болоод байна. Зарим улс оронд зөвхөн пестицидийн хэрэглээний талаар үндэсний хөтөлбөр хэрэгжүүлдэг.

#### ➤ Хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд хамгийн түрүүнд ямар асуудлыг шийдвэрлэх вэ?

Хамгийн түрүүнд пестицидийн төрөл, зөвшөөрөгдөх дээд хэмжээний стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох ажил байна.

Бидэнд хийх ажил их байна. Импортоор оруулж буй пестицидийн төрөл, хэрэглээ, хүнсний бүтээгдэхүүн дэх үлдэгдэл болон хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг хүн амын дунд судалдаг болох хэрэгтэй. Наад зах нь тухайн хүн пестицидийн ямар төрлийн химийн бодисоор хордсон, ямар түвшинд байгааг тогтоодог болох нь зүй.

Пестицидийг хэрэглэх эрүүл ахуйн дүрэм, стандарт зөрчсөнөөс, тээвэрлэх, хадгалах үеийн аюулгүй ажиллагаа алдагдсанаас хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй төдийгүй байгаль орчныг ч бохирдуулж байдаг аюултай.

Иймээс пестицидийн төрлүүдээс хоруу чанар багатайг нь сонгох, хэрэглээний стандартыг мөрдөж ажиллах, гадаад, дотоодын хүнсний бүтээгдэхүүнд хийх хяналтыг сайжруулахын зэрэгцээ одоо байгаа үйл ажиллагааг нэгтгэж, цогц тогтолцоо бий болгон хөгжүүлэх шаардлагатай байна.

Энэ тогтолцоог баг бөх, тогтвортой ажилладаг байлгахын тулд эрх зүйн орчин, хүний нөөц, дэд бүтэц, сургалт сурталчилгаа, санхүүжилт зэрэг асуудалд анхаарч ажиллах хэрэгтэй. Үүнд:

Дүрэм журам, стандартаа шинэчлэх, шинжилгээ, судалгаа хийх, сургалт зохион байгуулах, гардан хариуцан ажиллах хүний нөөцөө бэлтгэх, хүн, хүнс, хөрсөнд шинжилгээ хийх лаборатори, тоног төхөөрөмжөөр хангах, тариаланчид болон

нийт ард иргэдэд пестицидийн тухай ойлголт, эрүүл мэндээ хамгаалах боловсрол олгох, одоо байгаа санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох шаардлагатай юм.

Үүнийг хэрэгжүүлэх хүрээнд “Хүнсний хангамж, аюулгүй байдлын эрдэмтдийн зөвлөл” хуралдан пестицидийн асуудлаар хэлэлцэж, зөвлөмж гаргасан. Уг зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө гаргах юм. Удахгүй пестицидийн асуудлаар бүх талын оролцоог хангасан зөвлөлдөх хэлэлцүүлэг зохион байгуулж, үйл ажиллагааг улам эрчимжүүлэх төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэн ажиллана.

Энэ ажлыг хэрэгжүүлэхэд зөвхөн төр засаг дангаараа зүтгээд хангалттай үр дүнд хүрэхгүй. Салбарын ажилчид, эрдэмтэн судлаачид, нийт ард иргэд хамтран ажиллаж байж хүссэн үр дүндээ хүрнэ. Нэн ялангуяа, иргэд энэ асуудал ямар их ач холбогдолтой болохыг ойлгон дэмжиж ажиллах нь маш чухал юм. Иймд иргэдэд пестицидийн тухай сургалт, сурталчилгааг сайн хийж, ойлгуулснаар өөрийнхөө болон хайртай гэр бүл, үр хүүхдийнхээ эрүүл мэндийг хамгаалах юм.

Мөн мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг, импортын хүнсний бүтээгдэхүүн оруулж ирдэг иргэд, аж ахуйн нэгжүүдэд пестицидийн эрсдэлийн талаар мэдлэг олгох, тэднийг гарын авлага, зөвлөмж, ном сурах бичгээр хангах асуудлууд ч чухал байна.

Байгаль орчноо, хүн амын эрүүл мэндээ хамгаалах, хүнсний чанар, аюулгүй байдлыг анхаарч, хүртээмжтэй хангах энэ үйл хэрэгт Монгол улсын иргэн бүр идэвхтэй оролцохыг уриалж байна. Та бидний санаа зориг нэгдэж, хамтран ажиллах нь бодит үр дүн, амжилтын үндэс болно.

Хүн өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалахын төлөө ажиллана гэдэг нь эх орноо хамгаалж байна л гэсэн үг юм.

➤ **Танд дахин талархсанаа илэрхийлж, ажлын амжилт хүсье.**  
Баярлалаа.

Ярилцсан: Б.Урантуяа

# Эрдэмтдийн зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэл хийж, өргөжлөө



**Э**рдэмтдийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай 153-р захирамж 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр батлагдлаа. Тус захирамжийн хүрээнд ХХААХҮЯ, ЭМЯ, БШУЯ-ны төлөөллүүд нэмэгдэж, зөвлөлийн үйл ажиллагааны цар хүрээ тэлж байна. Нийт 22 эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн тус зөвлөл төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр эрчтэй өрнөж буй энэхүү хөдөлгөөнийг зөв чиглүүлэх “луужин” болох юм.

Улс орны хөгжил дэвшил, тогтвортой хөгжлийн зорилтуудыг ханган хэрэгжүүлэхэд хүнс, хөдөө аж ахуйн салбарын шилдэг боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлэх явдал туйлын чухал юм.

Үүний зэрэгцээ Эрдэмтдийн зөвлөлийн баг бүрэлдэхүүн 2025 онд Хүнсний аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхэд түлхүү анхаарч ажиллах болжээ. Тухайлбал эрдэмтдийн зөвлөлийн IV хуралдаанаар ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд пестицидийн үлдэгдлийн хэмжээг тодорхойлох, эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангаж байгаа болон экологийн цэвэр бүтээгдэхүүн эсэхийг шинжилгээ судалгааны үр дүнгээр нотлох, энэ талаарх судалгаанд төр, засаг, холбогдох мэргэжлийн байгууллагууд онцгой анхаарах, мэргэжилтэн бэлтгэж, лабораторийн хүчин чадлыг сайжруулах шаардлагатай байгааг эрдэмтэд, судлаачид хэлж байлаа.



## ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

**Ч.ДАВААБАЯР**

Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх, Доктор PhD, профессор;

## ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

**Д.ЕСӨН-ЭРДЭНЭ**

ХАА-н ухааны Доктор (Ph.D) ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга / Зөвшилцсөнөөр/;

**Б. БАТХҮҮ** Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн захирал /Зөвшилцсөнөөр/;

**А.БАКЕИ** Хөдөө аж ахуйн их сургуулийн эдийн засгийн шинжлэх ухааны доктор (PhD), профессор, академич / Зөвшилцсөнөөр/;

**А.НАРАНТУЯА** Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, доктор (PhD) / Зөвшилцсөнөөр/;

**С.ӨНӨРСАЙХАН** Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал, доктор (PhD) / Зөвшилцсөнөөр/;

**О.НАНДИН-ЭРДЭНЭ**

АУ-ны доктор, ХАБҮЛЛ-ийн Ерөнхий захирал, ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн гишүүн / Зөвшилцсөнөөр/;

**Б.БААСАНСҮХ** Хөдөө аж ахуйн их сургуулийн захирал, доктор (PhD), профессор / Зөвшилцсөнөөр/;

**Ж.ТУЯАЦЭЦЭГ** Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн, Үйлдвэрлэл технологийн сургуулийн захирал, доктор (PhD), профессор /Зөвшилцсөнөөр/;

**Х.ЦЭВЭЛМАА** Монгол Улсын их сургуулийн Эдийн засгийн хүрээлэнгийн захирал, Доктор (PhD), профессор / Зөвшилцсөнөөр/;

**Н.БАЯРСҮХ** Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн захирал, доктор (PhD), профессор /Зөвшилцсөнөөр/;

**Б.БАТЦЭЦЭГ** Мал эмнэлгийн хүрээлэнгийн захирал, доктор (PhD), профессор / Зөвшилцсөнөөр/;

**Ж.ЭНХТУЯА** Мал эмнэлгийн ухааны доктор PhD, НҮБ-ын ХХААБ-ын Нэг эрүүл мэнд-Бичил биетний тэсвэржилт төслийн менежер

**М.БЯМБАСҮРЭН**

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, доктор (ScD), дэд профессор /Зөвшилцсөнөөр

**Ч.БАТТОГТОХ** АУ-ын доктор, дэд профессор, Био-Анагаахын хүрээлэнгийн захирал, ХСХТэнхимийн эрхлэгч /Зөвшилцсөнөөр/;

**М.УНДРАМ** АУ-ны доктор, НЭМҮТ-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны хэлтсийн даргын үүргийг хавсран гүйцэтгэгч, Хоол судлал, хүнсний аюулгүй байдлын албаны дарга / Зөвшилцсөнөөр/;

**Ж.МӨНХЦЭЦЭГ** АУ-ы доктор, профессор, АШУУИС-ийн Био-Анагаахын сургуулийн Биохимийн тэнхимийн эрхлэгч /Зөвшилцсөнөөр/;

**Д.ЭНХМАА** химийн ухааны доктор, профессор, АШУУИС-ийн Био-Анагаахын сургуулийн Химийн тэнхимийн эрхлэгч, Био-Анагаахын хүрээлэнгийн Биологийн химийн лабораторийн эрхлэгч /Зөвшилцсөнөөр/;

**С.ЦЭРЭНЧИМЭД** Химийн мэргэшсэн инженер, Гаалийн төв лабораторийн дарга / Зөвшилцсөнөөр/;

**Б.ОЧИРХУЯГ** Доктор PhD, Дэд профессор МУИС-ийн Багш

**Ц.СОНИНХИШИГ** ХААУ-ны доктор, ШУТИС БАТС-ийн багш, дэд профессор, Монголын Хоолзүйчдийн Холбооны тэргүүн /Зөвшилцсөнөөр/;

**Г.ОЮУН** “САМО” институтын захирал, доктор (PhD) / Зөвшилцсөнөөр/.

**Л.ЭРХЭМБАЯР** ХАА-н ухааны Доктор PhD Монголын мал зүйч үржүүлэгчдийн үндэсний холбооны тэргүүн

## ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

**Т.НАСАНЖАРГАЛ** ХААИС-ийн багш доктор;



## Мэндчилгээ

Ерөнхийлөгчийн хот, хөдөөгийн  
бодлогын зөвлөх  
Г.Ганболд



**М**онгол улсын Ерөнхийлөгч санаачлан дотоодоос хүнсээ бүрэн хангах “Хүнсний хувьсгал” өрнүүлснээр УИХ-аас 36 дугаар тогтоол гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн нь дэлхий нийтийн тогтворгүй байдал, байгаль цаг уурын өөрчлөлтийн үед тохиолдох аливаа эрсдэлээс сэргийлэх, ялангуяа хүнсээ дотоодоосоо хангах нөхцөлийг цаг алдалгүй бүрдүүлэхийг гол зорилгоо болгосон гэж ойлгож болно. “Хүнсний хувьсгал” өрнүүлснээр энэхүү зорилгод хүрэх замд дэвшил гарсан гэдгийг статистик тоо харуулж байна. Сүүлийн хоёр жилд улсын хэмжээнд хүнсний чиглэлийн 24 үйлдвэр шинээр байгуулагдаж, 1500 ажлын байр нэмэгджээ. 200 гаруй нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг шинээр үйлдвэрлэж эхэлсэн байна.

Төрийн тэргүүний санаачилсан энэхүү амин чухал хөдөлгөөнийг хэрэгжүүлэх УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах, санал дүгнэлт гаргах ажлын хэсэгт миний бие орж ажилласан бөгөөд ажиллаж байх хугацаанд УИХ-ын гишүүд, эрдэмтэд судлаачид бүгд санал нэгтгэжгээр уг тогтоол гаргахыг дэмжиж байсан нь нэн тулгамдсан асуудал гэдгийг нотолж байлаа. 2022 оны байдлаар манай улс хүнсний бүтээгдэхүүнийхээ 50 орчим хувийг импортоор авч, ойролцоогоор 3 их наяд гаруй төгрөгийг валют болгон гаргаж байсан юм. “Хүнсний хувьсгал” өрнүүлж эхэлснээр орон нутагт иргэд экологийн цэвэр хүнс үйлдвэрлэх ажил эрчимжин хөнгөлөлттэй зээлэнд хамрагдаж, төрийн олон дэмжлэг туслалцааг хүртэж байна. Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зөвхөн 2023 онд 2000 орчим аж ахуйн нэгж, иргэнд нийт 832,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийн зээл олгосон нь үр дүнгээ өгч эхэлж байна.

“Хүнсний хувьсгал”-ын зорилго бол иргэдийн эрүүл зөв амьдрал, хүний бие махбодийн хэрэгцээ

шаардлагад нийцсэн аюулгүй, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах төдийгүй улмаар эхний ээлжинд бүс нутагтаа экспортлогч орон болох зорилтыг дэвшүүлсэн билээ. Ганцхан жишээ дурдахад хүнсний бүтээгдэхүүн, түүн дотор мах, махан бүтээгдэхүүний экспорт 2023 онд 80.4 мянган тоннд хүрч, 2022 оноос даруй 64.4 мянган тонноор нэмэгдсэн байна. Энэ мэт тодорхой өсөлт, амжилт байгаа ч бидэнд цаашид хууль эрхзүйн орчныг улам боловсронгуй болгох, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, малаа эрүүлжүүлэх, 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр хангах зорилтдоо хүрэх, хүнсний сүлжээ, хяналтын тогтолцоог сайжруулах зэрэг чиглэлд хийх ажил их байна.

Мөн цаашид “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнийг дэмжихээ илэрхийлсэн НҮБ, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллага, бусад улс орны санал санаачилга, дэмжлэгийг оновчтой ашиглах нь зүйтэй. Хувийн хэвшлийн компани, малчдын хоршоо, иргэдийн бизнес эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх, ялангуяа экспорт хийхэд нь туслах, олон улсын зах зээлд гарахад дэмжлэг үзүүлэх нь маш чухал юм.

Төрийн бодлогын нэгдмэл байдал чухал байна. Тиймээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар нь Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл монгол хүн”, “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Тэрбум мод” зэрэг хөдөлгөөнүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангах, “Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд амьдралдаа сэтгэл хангалуун, ажлын байртай, аюулгүй орчинтой “Эрүүл монгол хүн”-ий төлөө манлайлан ажиллаж байна.



## “АЛТАН НАМАР-2024”

**М**онгол Улс атар газар эзэмшсэний 65 жилийн ой, “Хүнсний хангамж-аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулж буй “Алтан намар-2024” ургацын баяр Дархан-Уул аймгийн Дархан хотод боллоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх атар газар эзэмшсэний 65 жилийн ойн баярын хуралд оролцож үг хэллээ.

Тэрбээр хэлсэн үгийнхээ эхэнд Монгол Улс атар газар эзэмшсэний 65 жил, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам байгуулагдсаны 100 жилийн ойн баярын мэндийг салбарын үе үеийн ажилтан, албан хаагч, малчин, тариаланч, үйлдвэрлэгч, баялаг бүтээгчдэд хүргэж, талархал илэрхийлэв.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улс ард иргэдийнхээ хүнсний хэрэгцээг хангах, экспортлох зорилгоор Атрын гурван удаагийн аяныг үндэсний хэмжээнд өрнүүлж байсан түүх, ололт амжилтыг дурдлаа.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын нэг чухал асуудал нь хүн амаа эрүүл, аюулгүй орчин, найдвартай, эрүүл хүнсээр хангах явдал бөгөөд байгаль орчин, хүнсний хангамж, аюулгүй байдалд онцгой анхаарах ёстойг онцоллоо.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгч “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл монгол хүн” болон “Цагаан алт” зэрэг үндэсний хөдөлгөөнүүдийг улс орон даяар санаачлан хэрэгжүүлж байгааг тэмдэглэв.

Тухайлбал, “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд төр, захиргааны 35 байгууллага хамтран ажиллаж, хууль дүрэм, төсөв санхүү, хөнгөлөлттэй зээл, гааль татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөс эхлүүлээд 114 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байгаа юм.

Үндэсний хөдөлгөөн хэрэгжсэн сүүлийн хоёр жилийн хугацаанд арилжааны банкаар дамжуулан 5-6 хувийн хүүтэй, 3-5 жилийн хугацаатай, нийт 1.3 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 3,100 орчим хүнс үйлдвэрлэгч, баялаг бүтээгч иргэн, аж ахуйн нэгжид олгоод байна.

Үүний үр дүнд хүнсний салбарт нийт 24 хүнсний үйлдвэр

шинээр ашиглалтад орж, 2023 оны байдлаар хүнсний ногооны хэрэгцээний 85 хувийг дотоодоосоо хангаж чадсаныг Монгол Улсын Ерөнхийлөгч хэлсэн үгэндээ тэмдэглэв.

Үндэсний хөдөлгөөнүүдийг амжилттай хэрэгжүүлснээр байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжилд шинэ боломж нээгдэж, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжил хангагдах, худалдаа, экспорт, хөрөнгө оруулалт, ажлын байр нэмэгдэх, ядуурал буурах зэрэг олон эерэг үр дүн гарна гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийллээ.

Монгол Улс “Эрүүл хүнс үйлдвэрлэгч, хүнс экспортлогч орон” болох зорилтын хүрээнд Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгууд буюу төвийн бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгон хөгжүүлэхээр зорьж байна.

Энэ хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг Дархан-Уул аймагт шилжүүлэн байршуулахаар Улсын Их Хурал, Засгийн газраас шийдвэр гарсан юм.

Цаашид байгаль орчинд ээлтэй, бүсчилсэн хөгжил болон тогтвортой хөгжлийг дэмжсэн газар тариалангийн салбарыг хөгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил, үр дүн гарах учиртайг Ерөнхийлөгч тэмдэглэлээ.

Тодруулбал, төр, хувийн хэвшлийн зүгээс:

- Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, шороон шуургыг бууруулж, ногоон хөгжлийг дэмжсэн, дэвшилтэт технологи, инновацад суурилсан, дэлхийн жишигт нийцсэн, экспортод чиглэсэн газар тариалангийн салбарыг хөгжлийн шинэ түвшинд гаргах цогц шинэчлэл, бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Бүсчилсэн хөгжлийг дэмжсэн газар тариалангийн кластер, цогцолборуудыг байгуулах, түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын нэгдсэн тогтолоо, жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулах, тэвэр логистикийн оновчтой сүлжээг бий болгох, боловсон хүчнийг бэлтгэх;
- Эрүүл ахуй, чанарын асуудлыг шат шатандаа анхаарч, аюулгүй байдлын хяналтыг эрс чангатгах;
- Төсөв, хөрөнгийн нөөц боломжоо бүрэн дүүрэн зөв ашиглаж, зээл санхүүжилт, татвар, даатгал зэрэг санхүүгийн



## УРГАЦЫН БАЯР БОЛЛОО

хөшүүргүүдийг оновчтой, хүртээмжтэй ашиглаж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааг дэмжих зэрэгт анхаарах шаардлагатай байгааг онцлов.

Ингэснээр ард иргэдээ гарал үүсэл нь тодорхой, найдвартай, дотоодын эрүүл хүнсээр хангаж, ажлын байрыг нэмэгдүүлж, монгол хүний амьдралын чанар сайжирч, улмаар Монгол Улс хүнс экспортлогч орон болох боломж бүрдэнэ гэдгийг онцлон тэмдэглэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх эх орноо эрүүл хүнсээр хангах их үйлсэд хүнс, хөдөө аж ахуйн салбарын ажилтан, албан хаагчид, үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдийн дэмжлэг, манлайлал, хамтын ажиллагаа, харилцан ойлголцол хамгийн чухал гэдгийг мөн онцлон тэмдэглэж, хурлын оролцогчдод амжилт хүсэв.

Баярын хуралд УИХ-ын гишүүн, УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен, УИХ-ын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, УИХ-ын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд А.Н.Евсиков нарын албаны төлөөлөгчид, салбарын үе үеийн ажилтан, албан хаагчдын төлөөлөл, иргэд оролцлоо.

ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд А.Н.Евсиков Монгол Улс атар газар эзэмшсэний 65 жилийн ойн баярын мэндийг хүргэв.

Монгол Улсад шинжлэх ухааны үндэслэлтэй хөдөө аж ахуйн салбарыг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд ЗХУ-аас дэмжлэг үзүүлж, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийг нийлүүлж, мэргэжилтэн, зааварлагчдыг томилон явуулж байсныг дурдаж, хоёр улсын хамтын түүхийн баатарлаг хөдөлмөрийн хуудас мөн гэдгийг онцоллоо.

Цаашид Дархан-Уул аймаг, Дархан хот шинэчлэгдэн хөгжиж, энэ бүс нутагт шинэ үйлдвэрүүд байгуулагдаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд энэ

бүс нутгаас гаргаж буй экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлснээр ОХУ, Монгол Улсын худалдааны эргэлтийг өсгөх, тэнцвэржүүлэхэд хувь нэмрээ оруулна гэж үзэж байгаагаа хэлэв.

“Алтан намар-2024” ургацын баярын хүрээнд хүнсний ногоо, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн технологи, шилмэл малын үзэсгэлэн, дуудлага худалдааг Дархан хотноо зохион байгуулж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх үзэсгэлэнгээр зочлох үеэрээ хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын баялаг бүтээгч, тариаланч, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл, иргэдтэй уулзаж, техникийн парадыг үзэж сонирхлоо.

Ташрамд дурдахад, 1959 онд эхэлсэн Атрын анхдугаар аяны үр дүнд 10 сангийн аж ахуй, салбарын үндэсний мэргэжилтэн, боловсон хүчин бэлтгэх их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд шинээр байгуулагдаж, зургаан жилийн дотор 1 сая орчим га атар газрыг эзэмшиж, анх удаа 516 мянган тонн үр тариа хураан авсан түүхтэй.

Атрын хоёрдугаар аян 1976 онд эхэлж, үр дүнд нь 1989 оны байдлаар 1.2 сая га эргэлтийн талбайтай болж, 840 мянган тонн үр тариа, 155 мянган тонн төмс, хүнсний ногоо, нэг сая гаруй тонн таримал тэжээл, хадлан хураан авч байсан юм.

Гэвч нийгэм, эдийн засгийн шилжилтээс улбаалан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт сорилт тулгарч, үр тариа, гурилынхаа 70 гаруй хувь, төмс, хүнсний ногооны 50 гаруй хувийг импортоор авч, үр тарианы ургацын хэмжээ 2005 он гэхэд 77 мянган тоннд хүрсэн нь атрын хоёрдугаар аяны үеэс 90 гаруй хувиар буурсан үзүүлэлт болж байв.

Монгол Улсын Засгийн газар 2008-2010 онд Атрын гуравдугаар аян болох Тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг дэвшүүлэн хэрэгжүүлснээр тариалангийн эргэлтийн талбайг 650 мянган га-д хүргэн сэргээж, улаанбуудай, төмсөөр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж чадсан юм.



Энэхүү арга хэмжээнд хүнс хөнгөн үйлдвэрийн 100 гаруй байгууллага, хувиараа бизнес эрхлэгч өөрсдийн бүтээгдэхүүнээр хоёр өдрийн турш үзэсгэлэн гарган оролцлоо.

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Хүнс, хөдөө аж ахуйн салбарын шилдэг үйлдвэрлэгчийг жил бүр шалгаруулж урамшуулахаар заасан. Энэ хүрээнд “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн, “Алтан намар-2024” баярын хурлаар Хүнс, хөдөө аж ахуйн салбарын шилдэг 10 үйлдвэрлэгчийг бүс бүрээс шалгаруулсан юм.

Монгол Улсын иргэдийг эрүүл хүнсээр хангах их үйлсэд манлайлан оролцож буй

- АПУ дэйри ХХК,
  - Хангай миллс ХХК,
  - ХКУ ХХК,
  - Завхан аймгийн “Мөнхөд мандаг” хоршоо,
  - Тайванбадрах хоршоо,
  - Дорнод аймгийн “Дорнод гурил” ХХК,
  - Дундговь аймгийн “Мандалговь хүнс” ХХК,
  - Хөвсгөл аймгийн “Хөвсгөл алтандуулга” ХХК,
  - Өвөрхангай аймгийн “Дээжийн өргөө” ХХК,
  - Дархан-Уул аймгийн “Дархан цасхан сүү” ХХК-иуд
- 2024 оны шилдэг үйлдвэрлэгч боллоо.



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ Дархан хот дахь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд ажиллалаа

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх “Алтан намар-2024” ургацын баярын үйл ажиллагаанд оролцсоныхоо дараа Дархан хот дахь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны шинэ байранд ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч энэ үеэрээ яамны удирдлагын бүрэлдэхүүнтэй уулзаж, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын нэгдсэн бодлого төлөвлөлт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хангамж, аюулгүй байдал буюу “Хүнсний хувьсгал” болон “Цагаан алт” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар санал солилцов. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр энэ үеэр яам Дархан-Уул аймагт шилжсэнээр салбарын хөрөнгө оруулалтын бодлогыг төвийн бүс рүү чиглүүлж, хүнсний болон хөнгөн үйлдвэрийн кластерууд, бусад төрлийн үйлдвэрлэлийг төвийн бүсэд хөгжүүлэхээс гадна тариалангийн эргэлтийн талбайг 200 мянган га-гаар нэмэгдүүлэхээр төлөвлөж байгааг онцоллоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч ирэх таван жилд гол нэр төрлийн 19 хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын

хэрэгцээгээ бүрэн хангах, цаашид хүнс экспортлогч орон болох зорилтыг дэвшүүлж “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг санаачлан хэрэгжүүлж байгаа билээ.

Үндэсний хөдөлгөөнийг амжилттай хэрэгжүүлж, бодит үр дүнд хүргэх зорилгоор Монгол Улсын Их Хурал 36 дугаар тогтоол баталж, хүнс, хөдөө аж ахуйн салбарт ирэх таван жилийн хугацаанд 1.7 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт, санхүүжилт хийхээр шийдвэрлэж, Засгийн газарт тодорхой үүрэг, даалгавар өгсөн.

Түүнчлэн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг буюу төвийн бүс нутгийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгохоор төлөвлөсөн. Энэ хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг Дархан-Уул аймагт шилжүүлэн байршуулах шийдвэр гарсан юм.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг Дархан-Уул аймагт шилжүүлэн байршуулах шийдвэр үе шаттайгаар хэрэгжиж, яамны бүрэлдэхүүний эхний ээлж, Хөдөө аж ахуйн корпорац, Хөдөө аж ахуйн бирж Дархан хотноо шилжин ирсэн байна.

**Мэндчилгээ**

**Ерөнхийлөгчийн  
Эдийн Засгийн Бодлогын зөвлөх  
Б.Даваадалай**



**У**дам нутаг шигээ холч ухаант, хөдөлмөрч түмний төлөөлөл болсон хүнс үйлдвэрлэгчид, эрдэмтэн судлаачид, төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтнүүд, хувийн хэвшлийнхэндээ энэхүү сэтгүүлээр дамжуулан чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж, энэ өдрийн мэндийг айлтгая.

Хөдөө аж ахуйн салбар бол эдийн засгийг солонгоруулахад хамгийн гол үүрэг гүйцэтгэх, ард иргэдийг хоолтой, ундтай, өмсөх хувцастай, 300 гаруй мянган хүнийг ажилтай, орлоготой болгож байгаа, Монгол Улсын хөгжлийн хамгийн чухал, тулгуур салбаруудын нэг юм.

Тийм ч учраас Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Хүнсний хувьсгал”-тай хослуулан “Цагаан алт” үндэсний хөдөлгөөнийг санаачлан эхлүүлээд байна.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд хүнсний болон хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг дэмжсэн олон ажил хийгдсэн. Илүү нарийвчилсан бодлогоор, малчин ардаа дэмжих, малын гаралтай түүхий эдийг үнэ цэнтэй болгох цаг үеийн шаардлага бий.

Тухайлбал, малчид барьцаа хөрөнгө багатай, банкны шалгуурыг давах чадвар сул зэргээс шалтгаалан “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд олгосон бага хүүтэй, урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийг мал аж ахуйн салбарынхан ашиглахад тодорхой хүндрэл, бэрхшээлүүд үүсээд байсан.

Тиймээс “Цагаан Алт” үндэсний хөдөлгөөнийг санаачлан, ноос, ноолуур болон арьс ширийг үнэ цэнтэй болгох, эдгээр гурван чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжих, бүсчилсэн загвар үйлдвэрийн паркуудыг байгуулахаар зорьж байна.

Өнөөдрийн байдлаар хөнгөн үйлдвэрлэлийн бараа



бүтээгдэхүүний экспорт манай улсын нийт экспортын дөнгөж зургаан хувийг бүрдүүлж байна. Харин нөгөө талдаа хүнс, гутал, хувцас, арьс, савхин эдлэлээс эхлээд хөнгөн үйлдвэрлэлийн шинжтэй бараа бүтээгдэхүүн гадаадаас худалдан авахад жилд ойролцоогоор гурван тэрбум орчим ам.долларыг монголчууд бид гадагшаа урсгаж байна.

Өөрөөр хэлбэл, олон зуун жилийн нүүдлийн мал аж ахуйн соёлтой, 60 гаруй сая малтай манай улс малын гаралтай түүхий эдээ бүрэн боловсруулж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

Монгол улс жилдээ 36 мянган тонн хонины ноосны нөөцтэй хэдий ч үүний 75 хувийг нь нэмүү өртөг шингээлгүй зөвхөн угаагаад экспортолж байна. Судалгаанаас харахад хэрэв хонины ноосоо дотооддоо бүрэн боловсруулж чадвал энэ салбарын орлого 5-6 дахин нэмэгдэх боломжтой байгаа юм.

Мөн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө эрчимжиж, ган зудын давтамж жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь бэлчээрийн мал аж ахуйд суурилсан манай улсын хүнс, хөдөө аж ахуйн салбар цаашид тогтвортой хөгжих, орон нутгийн иргэд, малчдын орлого өсөхөд томоохон эрсдэл, хязгаарлалт болж байна.

Иймд хөдөө аж ахуйн салбарын 90 гаруй хувийг бүрдүүлж буй гол тулгуур мал аж ахуйн салбараа дорвитой хөгжүүлж, бодит ахиц гаргаж, малчид, орон нутгийн иргэдийнхээ амьжиргааг сайжруулахаар эрчимтэй ажиллаж эхэллээ.

Цаашид хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг шинэ шатанд гаргах, тэр дундаа өсөн үрждэг баялаг болох ЦАГААН АЛТ болсон мал, малын гаралтай түүхий эдийг үнэ цэнтэй болгох, үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулах чиглэлд бодит үр дүнд хүрэх боломж бий.



# “Хүнсний хувьсгал” Мэргэжлийн холбоо байгуулагдаад хоёр жил боллоо

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний үр дүнг эрчимжүүлэх үүрэг бүхий “Хүнсний хувьсгал” Мэргэжлийн холбоог хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэргэжлийн холбоод нэгдэн Дэлхийн хүнсний өдрөөр үүсгэн байгуулсан.



### Энэхүү мэргэжлийн холбоо нь:

- Хүнс, хөдөө аж ахуйн салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, кластераар хөгжүүлэх
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн болон аж үйлдвэрийн салбарын оролцогчдын эрх ашгийг хамгаалах
- Экспортыг дэмжих гэсэн үндсэн зорилготой

### Хийсэн ажлууд:

Үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн Удирдах зөвлөлийн гишүүд нийт долоон удаагийн хурал зохион байгуулж, зорилго, үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлж, зөвлөмж гаргаж, хөдөө аж ахуйн салбарын ААН-үүдийн дуу хоолой болон ажиллаж байна. Мөн Монгол Улсын Ерөнхий сайд, ХХААХҮ-ийн сайд, УИХ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга,



“Хүнсний хувьсгал” Мэргэжлийн холбооны  
Гүйцэтгэх захирал М.Болод

Нийслэлийн Засаг дарга, МЭЕГ, УИХ-ын дарга, Шадар сайд нартай уулзалт зохион байгуулж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, салбарт тулгамдаж буй асуудлыг хамтран шийдвэрлэх арга замуудын талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн. Энэ хүрээнд:

- Дүүргийн захирамжтай газарт А даалгавар өгдөг болсон
- Хүнсний үйлдвэрлэлийн зориулалтаар баригдсан, өргөжүүлэн барьсан үл хөдлөхийн гэрчилгээгээ аваагүй байгаа аж ахуйн нэгжүүдэд нэг удаа өршөөл үзүүлж гэрчилгээг шийдвэрлэсэн.



## Үр дүнгийн буухиа үргэлжилсээр...

Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн тухайд 2023 оны байдлаар 889 аж ахуйн нэгж, 1067 иргэнд нийт 832,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийн зээл олгосон бол өнөөдрийн байдлаар 2024 онд 1157 аж ахуйн нэгж, иргэнд нийт 360,4 тэрбум төгрөгийг олгоод байна.

Хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийн зээл

2023 онд

889

аж ахуйн  
нэгжид

1067

иргэнд

НИЙТ

832,7

тэрбум төгрөг

2024 онд

1157

аж ахуйн нэгж, иргэнд

НИЙТ

360,4

тэрбум төгрөг

### Зээлийн зарим үр дүн: (нийт 24 үйлдвэр)

#### Хангайн бүсэд:

(Архангай, Баянхонгор,  
Өвөрхангай аймаг)

Баянхонгор аймгийн Баянхонгор суманд 2023 онд 100 толгой бод, 1000 толгой бог мал төхөөрөх хүчин чадалтай мал төхөөрөх, боловсруулах нэг үйлдвэр шинээр ашиглалтад орсон.

2024 онд “Монгол Сарлаг” төслийг Архангай аймгийн Чулуут суманд сарлагийн сүүгээр үйлдвэрлэсэн уламжлалт сүү цагаан идээг эрүүл ахуй, чанарын шаардлага хангасан гэр үйлдвэрлэлийн стандартыг нэвтрүүлж, MONT-YAK брэндийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна. (9 нэр төрөл)

Архангай аймгийн Булган суманд 2024 онд 100 толгой бог, гурван толгой бод төхөөрөх хүчин чадалтай, мал төхөөрөх нэг, Рашаант суманд жилд гурван тн уураг үйлдвэрлэх хүчин чадалтай сүүний уураг боловсруулах үйлдвэрийг шинээр ашиглалтад оруулаад байна. (нийт 4 үйлдвэр)

#### Баруун бүсэд:

(Баян-Өлгий, Говь-Алтай,  
Завхан, Увс, Ховд аймаг)

Баян-Өлгий аймгийн Толбо суманд 2023 онд өдөрт 80 толгой бог, 20 толгой бод мал төхөөрөх хүчин чадалтай мал төхөөрөх үйлдвэрийг ашиглалтад оруулсан. (нийт 1 үйлдвэр)

#### Хойд бүсэд:

(Булган, Орхон, Хөвсгөл  
аймаг)

Хөвсгөл аймгийн зургаан суманд (Арбулаг, Алаг-Эрдэнэ, Бүрэнтогтох, Түнэл, Тариалан, Эрдэнэбулган) бяслаг боловсруулах зургаан үйлдвэрийг шинээр ашиглалтад оруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. (нийт 6 үйлдвэр)

#### Улаанбаатарын бүсэд:

Нийслэлийн Налайх, Сонгинохайрхан дүүрэгт хоногт 100-200 толгой бод, 500-1000 толгой бог төхөөрөх хүчин чадалтай мал төхөөрөх хоёр үйлдвэр, хоногт 40-150 тн мах боловсруулах хоёр үйлдвэр, Сонгинохайрхан дүүрэг хоногт 2.0 тн гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай “Өв соёл” хүнсний нэг үйлдвэр, нийслэлийн төвд хоногт 200-400 кг гурилан бүтээгдэхүүн боловсруулах хүчин чадалтай хүнсний нэг үйлдвэр, Баянгол дүүрэгт хоногт 10.0 тн сүүн бүтээгдэхүүн боловсруулах хүчин чадалтай сүүн бүтээгдэхүүний нэг үйлдвэр, нийт 6 үйлдвэр шинээр ашиглалтад орсон байна.

Сүү үйлдвэрлэгч томоохон аж ахуйн нэгж болох АПУ дэйри ХХК 8000 м2 үйлдвэрийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Мөн Витафит милк ХХК 20.1 га талбай бүхий газарт 13000 м2 барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд автомат иж бүрэн савлагаатай тоног төхөөрөмжийг суурилуулах замаар шинээр сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулах ба гүйцэтгэл 50 гаруй хувьтай явж байна.



**Төвийн бүсэд:**  
(Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг);

Сэлэнгэ аймгийн Мандал суманд хонин нуга брэндийн хоёр төрлийн органик бяслаг, үнээний сүүнээс гаргаж авсан тансаг зэрэглэлийн сүүн шимийн архи, хоёр төрлийн цэвэр ус үйлдвэрлэх зэрэг нийт гурван үйлдвэр шинээр ашиглалтад оруулсан. Дархан-Уул аймагт хоногт 130 толгой бод, 600 толгой бод мал төхөөрөх хүчин чадалтай мал төхөөрөх нэг үйлдвэр, нийт дөрвөн шинээр ашиглалтад орсон байна.

**(нийт 4 үйлдвэр)**

Дархан-Уул аймагт Өег гурил ХХК хүнсний улаанбуудай хадгалах зориулалтын 28000 тн агуулах бүхий силосыг барьж байгуулахаар ажиллаж бөгөөд гүйцэтгэл 50 хувьтай байна.

**Зүүн бүсэд:**

Сүхбаатар аймгийн төвд 2023 онд хоног 200 бод, 1000 бог төхөөрөх хүчин чадалтай мал төхөөрөх 1, Хэнтий аймагт хоногт 200 толгой бод, 800-1000 бог мал төхөөрөх хүчин чадалтай мал төхөөрөх, боловсруулах 1 үйлдвэр, Өмнөдэлгэр суманд хоногт 30 толгой бод, 200 толгой бог төхөөрөх хүчин чадалтай мал төхөөрөх, 90.0 тн мах боловсруулах хүчин чадал бүхий нэг, Жаргалтхаан суманд хоногт 150-200 толгой бод, 800-1000 толгой бог мал төхөөрөх хүчин чадалтай мал төхөөрөх болон боловсруулах нэг, нийт дөрвөн үйлдвэр шинээр ашиглалтад орсон байна. **(нийт 4 үйлдвэр)**

**Шинээр нэмэгдсэн нэр төрөл, ажилчдын тоо**

2023 онд мах, сүү, исгэлт, жимс, жимсгэнэ, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 400 гаруй шинэ нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн бол 2024 оны гуравдугаар улирлын байдлаар 600 орчим болж өссөн байна. Мөн 2023 онд ажиллагсдын тоо 900 -гаар нэмэгдсэн бол 2024 онд 1500 гаруй болж нэмэгдсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Жагсаалт батлах тухай” 107 дугаар тогтоолоор хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, тухайн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас хөнгөлөхөөр заасан.

Дээрх тогтоолын хэрэгжилтийн үр дүнгээс үзэхэд 2023 онд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын нийт 121 аж ахуй нэгжийн 57.1 тэрбум төгрөгийн импортын бараа бүтээгдэхүүнд 2.1 тэрбум төгрөгийн буцаан олголтыг 2024 оны нэг дүгээр улиралд багтаан олгосон. Улсын төсөвт 5.7 тэрбум төгрөгийн татварын орлогыг бүрдүүлсэн байна.




## Мах, махан бүтээгдэхүүний салбар:





### А. Боловсруулсан мах

Дотоодын үйлдвэрт 2023 онд хонины мах 10.1 мянган тонн, адууны мах 21.4 мянган тонн, үхрийн мах 8.7 мянган тонн, ямааны мах 9.4 мянган тонн, дайвар бүтээгдэхүүн 0.6 мянган тонн боловсруулж нийтдээ 50.1 мянган тонн мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулсан. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 2.3 дахин өссөн үзүүлэлт юм.



### Б. Мах, махан бүтээгдэхүүний экспортын гүйцэтгэл, мян.тн



### В. Мах, махан бүтээгдэхүүний экспорт, төрлөөр




Он	Хонь, ямааны түүхий мах	Адууны мах	Үхрийн мах	Дулааны аргаар боловсруулсан мах	Дайвар бүтээг	Нийт
	Нийт	26.1	0.6	2.8	0.1	32.2
2018	6.2	32.2	1.1	29.3	1.6	70.4
2019	7	30.8		18.4	2.4	58.6
2020	1.8	17.6		19.4	1.2	40.0
2021	0.5	8		13.4	0.9	22.8
2022	3.9	6.9	0.1	4.9	0.2	16.0
2023	12.6	32.9	0.2	32.9	1.7	80.4
2024.09.20	11.8	12.3	0.09	10.7	0.9	36.0



## Сүүний салбар:

### А. Боловсруулсан сүү:

Дотоодын үйлдвэрт 2023 онд 126.8 сая литр сүүг үйлдвэрийн аргаар боловсруулсан бол өмнөх онтой харьцуулахад 11.6 хувиар өссөн байна.



Нийт үйлдвэрлэсэн сүүний 15.5 хувьтай тэнцэх 126.8 сая литр сүүг үйлдвэрийн аргаар боловсруулан шингэн сүү, тараг, бяслаг, аарц, цөцгий зэрэг сүү, сүүн бүтээгдэхүүнийг 2023 онд дотооддоо үйлдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 4.0 хувиар өссөн байна. (боловсруулсан сүү, 2022 он 11.5%, 2023 он 15.5%)



## Гурил, гурилан бүтээгдэхүүний салбар:

Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх онтой харьцуулбал, гурилын үйлдвэрлэлийн хэмжээ 6.9 хувиар буурч, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 9.6 хувиар нэмэгдсэн байна.

Талх үйлдвэрлэх технологийн шугамын үйл ажиллагааг бүрэн автоматжуулснаар бүтээгдэхүүний савлалтын байдал сайжирч, хөдөлмөрийн бүтээмж 10-52 хувиар нэмэгдэхээс гадна хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал хангагдах нөхцөл бүрдэж байна.



## Үйл явдлын хураангуй



### “Хүнсний хувьсгал” Мэргэжлийн холбоо үйл ажиллагаагаа тогтвортой явуулан, үйлдвэрлэгчид рүү чиглэсэн олон ажил хийж байна

**Х**үнс, хөдөө аж ахуйн салбарын мэргэжлийн нэгдсэн холбооны нэгдэл “Хүнсний хувьсгал” Мэргэжлийн холбооны удирдах зөвлөлийн гишүүдийн VI хуралдаан боллоо. Хуралдаанаар Мэргэжлийн нэгдсэн холбооны хууль батлагдсантай холбогдуулан шийдвэр гаргах, өмнөх шийдвэрүүдийн биелэлттэй танилцаж ажлын хэсгүүдийн хэрэгжүүлж буй ажлын явцтай танилцах зэрэг найман асуудлуудыг хэлэлцлээ.

Мөн “Хүнсний хувьсгал” Мэргэжлийн холбооны Удирдах зөвлөлд “Харумафүжи сүүний ферм”-ийн үүсгэн байгуулагч Б.Бямбадорж, “Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийн нийгэмлэг”-ийн үүсгэн байгуулагч Б.Солонго, “Хөдөө аж ахуйн салбарын эрдэст нэмэлт, шим тэжээл үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-ын Тэргүүн О.Дашдулам нарын гурван гишүүн шинээр элслээ.



### “Биокомбинат” ТӨХХК-ийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарч, хамтран ажиллана

**Б**иотехнологийн үндэсний ууган үйлдвэр “Биокомбинат” ТӨХХК-ийн үйл ажиллагаатай Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр, Ерөнхийлөгчийн тамгын газрын Хүнсний төсөл, хөтөлбөр хариуцсан албаны дарга Т.Мөнхтөр болон Сангийн яам, Эдийн засаг хөгжлийн яамны албаны хүмүүс танилцлаа.

Тус үйлдвэр нь малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх биобэлдмэл үйлдвэрлэдэг улсын ганц үйлдвэр бөгөөд өнөөдрийн байдлаар 47 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.



### “Хүнсний хувьсгал”-ийн хүрээнд орон нутгийн лабораториудын арга зүйг чадавхжуулна



“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори”-т Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр, Ерөнхийлөгчийн тамгын газрын Хүнсний төсөл, хөтөлбөрийн албаны дарга Т.Мөнхтөр нар ажиллалаа. “Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори” нь мал амьтны гоц халдварт өвчнийг илрүүлэх, оношлох баталгаажуулах, экспорт импортын мал, амьтан, тэдгээрийн түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлэг эрүүл ахуйн баталгаа гаргах зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.



## Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ цэнийг өсгөж, олон улсын зах зээлд шинэ брэнд бий болгох боломжтой

“Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2024” эрдэмтдийн зөвлөлдөх уулзалт боллоо. Тус уулзалтад мал аж ахуйн чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг 20 гаруй эрдэмтэд, үндэсний үйлдвэрлэгчид оролцлоо.

“Mongol Made” нэгдэл ноосон бүтээгдэхүүнээр олон улсын зах зээлд өрсөлдөж малын гаралтай бүтээгдэхүүнээ дэлхийн брэнд болгохоор зорьж байна. Үүнтэй холбогдуулан эрдэмтдийн санал зөвлөгөөг сонсож, бүтээгдэхүүнүүдийнхээ үнэ цэнийг өсгөх цаашдын стратегия тодорхойлох зорилгоор тус зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулжээ. Мөн гарааны 9 бүтээгдэхүүнээ удахгүй танилцуулах бөгөөд Францын “MESSIEURS” дизайны агентлагтай хамтран бүтээгдэхүүнээ урлаж байгаа аж.



## “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд 2023 онд мал төхөөрөх, мах боловсруулах дөрвөн үйлдвэр ашиглалтад оржээ



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Траст трейд” ХХК-д /2024.05.07/ ажиллалаа. “Траст трейд” ХХК 2000 онд мах, махан бүтээгдэхүүн, хиам үйлдвэрлэл, гадаад, дотоод худалдааны чиглэлээр бага оврын тоног төхөөрөмж, түрээсийн байранд, зургаан ажилтантай үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бөгөөд үүнээс хойш өөрийн гэсэн үйлдвэр, гахайн аж ахуй, мах ангилах, боловсруулах үйлдвэр зэргийг ашиглалтад оруулж, одоогоор 70 гаруй төрлийн бүтээгдэхүүнээ дотоодын зах зээлд нийлүүлж байна. Эхний ээлжинд гадаадын таван улсад бүтээгдэхүүнээ экспортлохоор бэлтгэж байгаа аж.



## Монголдоо өсгөж буй тахианы махаар дотоодын зах зээлийн 20 хувийг хангахаар зорьж байна

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх “Ажигана” ХХК-ийн “Оргио” тахианы аж ахуйд ажиллалаа. “Оргио” тахианы аж ахуй нь эх сүрэг, инкубатор, дэгдээхэй бойжуулах байр, төхөөрөх цех, тэжээлийн үйлдвэр, итгэмжлэгдсэн лаборатори, мал эмнэлгээс бүрдсэн махны чиглэлийн тахианы иж бүрэн аж ахуй юм.

Манай улс жилд 22 мянга гаруй тонн тахианы махыг импортоор 50-60 сая ам.доллараар авч байна. Тахианы махны дотоодын хэрэглээ жил бүр 20 хувиар өсч байгаа бөгөөд өсөн нэмэгдэж буй дотоодын зах зээлийн 15 хувийг үндэсний үйлдвэрүүд хангаж байна. “Ажигана” ХХК-ийн “Оргио” үйлдвэр нь жилд 1,000 гаруй тонн буюу дотоодын тахианы махны хэрэглээний таван хувийг үйлдвэрлэдэг. Харин цаашид эх сүргийн хүчин чадлыг 50 хувиар нэмэгдүүлэх, автомат удирдлага, хяналтын систем нэвтрүүлэх, дотоодын тахианы махны хэрэглээний 20% бүрдүүлдэг болох зорилго тавиад байна.



## Пестицидийн хэрэглээнд хяналт тавих ажлын төлөвлөгөө гаргана



**М**онгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газраас хамтран зохион байгуулж буй “Пестицидийн хэрэглээний өнөөгийн байдал” сэдэвт зөвлөлдөх хэлэлцүүлэг Төрийн ордонд боллоо.

Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсэн, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Улсын Их Хурлын гишүүн С.Замира, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Ахлах зөвлөх Н.Хүрэлбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр болон салбарын төлөөлөл болсон 200 гаруй эрдэмтэн, албан хаагч оролцов.



Дэлхий дахины хөгжлийн шинэ чиг хандлага, уур амьсгалын өөрчлөлтөд Улсын Их Хурал гол анхаарлаа хандуулж, 2024 оны хаврын ээлжит чуулганаар Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийг шинэчлэн найруулж, баталсныг дурдав.



Газар тариалангийн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байгаагийн хэрээр пестицидийн тоо хэмжээ, нэр төрөл жилээс жилд нэмэгдэж, манай улс пестицидийн хэрэглээний бараг 90 хувийг импортоор хангадаг байна.

Энэ асуудалтай холбоотой байгууллагуудын уялдаа холбоо, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, сайжруулах, пестицидийн чанар, найрлагыг тодорхойлох лабораторийн хүчин чадал, хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, тариалан эрхлэгчдэд зөв зохистой хэрэглээг нэвтрүүлэхэд мэдээлэл сургалтыг зохион байгуулах, ургамал ургалтын хугацаанд өвчин, хортон, хог ургамалтай тэмцэхдээ мэргэжлийн сургалтад хамрагдсан байгууллага, иргэнээр хийлгэдэг байх, пестицидийн хэрэглээнд хяналт тавих тусгайлан эрх зүйн баримт бичигтэй болох зэрэг асуудлыг анхаарах шаардлагатай байгааг хурлын үеэр онцлов.

Зөвлөлдөх хэлэлцүүлэг “Пестицидийн талаарх эрх зүйн орчин, хэрэглээ”, “Химийн хортой болон аюултай бодисын эрх зүйн орчин, хэрэглээ”, “Пестицид хүний эрүүл мэндэд нөлөөлөх нь”, “Ургамал хамгаалал пестицидийн судалгааны өнөөгийн байдал”, “Хүний эрүүл мэнд ба пестицид судалгааны тойм”, “Хүнсний аюулгүй байдал ба пестицидийн үлдэгдлийн хяналт”, Пестицидийн талаар авах арга хэмжээнд эрдэмтдийн зөвлөлөөс гаргасан зөвлөмж” сэдвээр холбогдох салбарын эрдэмтэн судлаачдын илтгэлээр үргэлжилсэн юм.

Мөн энэ үеэр хуралдааны зөвлөмжийг бодитой хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргахаар 17 төрийн байгууллагаас бүрдсэн ажлын хэсэг байгуулагдлаа.





## Хаягдал аккумулятороос гурван төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортод гаргана

Монгол Улсад жил бүр хамгийн багадаа 7-8 тонн буюу 160 мянган ширхэг хар тугалгат хүхрийн хүчлийн батарей байгальд хаягддаг гэсэн судалгаа бий. Үүнээс ердөө 1,200 орчим тонн буюу 30 мянган ширхгийг нь стандартын бус аргаар дахин боловсруулж гадаадад экспортолж байна. Аккумуляторыг стандартын бус аргаар дахин боловсруулах нь хөрс, усыг хамгийн ихээр бохирдуулдаг байна. Тэгвэл байгаль орчинд ээлтэй технологиор хар тугалган батарейг дахин боловсруулдаг Дэлхийн жишиг үйлдвэрт Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх ажиллалаа.



## НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага нь мал аж ахуйн салбарт шинэ хөтөлбөр хэрэгжүүлнэ




Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр, ЕТГ-ын Хүнсний төсөл, хөтөлбөрийн албаны дарга Т.Мөнхтөр нар “НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага”-ын суурин төлөөлөгч Стивен Карбо, “НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага”-ын Вена хот дахь Төв оффисын захирал Али Бадарне, “НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага”-ын Төв оффис Төслийн менежер, Хүнсний аюулгүй байдлын мэргэжилтэн Габор Молнар болон “НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага”-ын Монгол дахь Хөтөлбөрийн зохицуулагч Г.Мөнхболор нарыг хүлээн авч уулзлаа.

Тус уулзалтаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар амжилттай хэрэгжиж буй “Хүнсний хувьсгал” болон хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг шат ахиулах зорилгоор хэрэгжүүлэх гэж буй “Цагаан алт” үндэсний хөдөлгөөнүүдийн хүрээнд НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллагатай хамтран ажиллах талаар санал солилцож, чиглэлээ тодорхойлон цаашдын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай асуудлуудын талаар хэлэлцлээ.


## Засгийн газраас Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн байгуулахыг дэмжлээ

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолоор “хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх”-ийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.



Засгийн газрын 2024 оны тав дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн “Хүнсний судалгаа инновацын нээлттэй төв”-ийг түшиглэн байгуулахаар боллоо. Хүрээлэн нь хүнсний аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний найрлага, бүтэц, уугуул гарал, биологийн төрөл зүйлийн судалгааг хөгжүүлэх, судалгаанд тулгуурлан шинэ мэдлэг бий болгох замаар төрийн бодлогод дэмжлэг үзүүлэх юм.

Ингэснээр хүнсний салбарын хөгжил шинэ шатанд гарах, хүнсний үйлдвэрлэлийг шинжлэх ухаанчаар хөгжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, бие даасан салбар шинжлэх ухаан болон хөгжих боломж бүрдэнэ. Мөн үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, үйлдвэрлэлд шинэ бүтээгдэхүүний технологи нэвтрүүлэх, нутагшуулах, хүнсний түүхий эд, үйлдвэрлэлийн шинэ эх үүсвэр бий болгох, хүнсний импортын хамаарлыг бууруулах зэрэг ач холбогдолтой гэж үзлээ. Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн байгуулахтай холбоотой зардлыг Боловсрол, шинжлэх ухааны яам 2024 оны батлагдсан төсвөөсөө гаргах бөгөөд цаашид жил бүрийн улсын төсөвт тусгах юм.



## Мэргэжлийн нэгдсэн холбоодын хууль батлагдсанаар Монгол Улс эдийн засгийн хувьд өндөр хөгжилтэй орнуудтай ижил түвшинд очих тогтолцоо бүрдэж байна

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль батлагдаж, Улсын их хурлын дарга 20 гаруй мэргэжлийн холбоодын төлөөлөлд гардууллаа. Хуулийн хүрээнд мэргэжлийн холбоод нэгдэж, төр, хувийн хэвшилтэй хамтарч ажиллах эрх зүйн орчин бүрдэх юм.

Энэхүү хуулийн зорилт нь мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах, түүнд тавигдах шаардлага, мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдал, зохион байгуулалт, үйл ажиллагааг тодорхойлох, төрийн байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулахад орших юм.



## Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр ашиглалтад орсноор нийслэлийн ус хангамж 80 хувиар нэмэгдэнэ

**М**онгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Мянганы сорилтын II Компакт гэрээний хүрээнд барьж буй дэвшилтэт технологи бүхий Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн бүтээн байгуулалттай танилцлаа.

Мянганы сорилтын II Компакт гэрээгээр Улаанбаатарчуудын усны хэрэглээг урт хугацаанд тогтвортой хангах, нийслэл хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх зорилготой. Хөтөлбөр АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн 350 сая ам.долларын буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын 111 сая хүртэлх ам.долларын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж байна.

### БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ 56 ХУВЬТАЙ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.

Хөтөлбөрийн хүрээнд Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах, Хаягдал ус дахин боловсруулах, Усны салбарын тогтвортой байдлыг хангах гэсэн харилцан уялдаа бүхий гурван томоохон төслийг 2026 оны гуравдугаар сарын 31-ний дотор багтаан хэрэгжүүлнэ. Үр дүнд нь Монгол Улсын усны салбарын дэд бүтцийг сайжруулж, хууль эрхзүй, бодлого зохицуулалтын шинэчлэлүүд хийж, Улаанбаатар хотын ус хангамж 80 орчим хувиар нэмэгдэнэ гэж тооцоолжээ.



## “Хүнсний салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг нэмэгдүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлэг боллоо

**Х**үнсний салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг нэмэгдүүлэх боломж” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид, төрийн болон төрийн бус байгууллага, хүнсний чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж буй мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, коллеж, их, дээд сургуулиудын төлөөлөл оролцлоо.

Тус хэлэлцүүлэг нь хүнсний үйлдвэрүүдийг мэргэжлийн хүний нөөцөөр хангах, хүнсний салбарын мэргэжилтэн бэлтгэж буй их, дээд сургууль, коллежийн элсэлтийг нэмэгдүүлэх, хүнсний мэргэжлийн онцлог, давуу талыг сурталчлан таниулах зорилготой юм.

“Дэлхийн хүнсний аюулгүй байдлын өдөр”-ийг тохиолдуулан СХЗГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, Монгол Улс дахь НҮБ-ын ХХААБ, ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн газрууд хамтран “Стандарт ба хүнсний аюулгүй байдал” сэдэвт үндэсний хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Тус хэлэлцүүлгээр Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын нөхцөл байдал, гарсан ахиц дэвшил, тулгарч буй сорилт бэрхшээлийг үнэлж дүгнэж, цаашид хэрэгжүүлэх ажил, анхаарах зүйлсийн талаар авч хэлэлцлээ.





### Бяруу, шүдлэн насны эр үхрийг 150 хоног бордон, гарах ашиг шимийг нь хоёр дахин нэмэгдүүлжээ



**М**онгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутаг Чандганы талд боссон дэлхийн жишигт нийцсэн хөдөө аж ахуйн цогцолборт ажиллалаа.

М-Си-Эс группийн хөрөнгө оруулалттай “Мэтагро” ХХК нь олон улсын стандартад нийцсэн өндөр чанартай хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг эрчимжсэн мал аж ахуй болон ухаалаг газар тариаланг хослуулан хөгжүүлэх замаар дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх зорилгоор 2021 онд байгуулагдсан. Тус компани өнөөдрийн байдлаар дэлхийн жишигт хүрсэн 5000 толгой үхрийн аж ахуй, тэжээлийн аж ахуй, Евро стандартын мах боловсруулах үйлдвэр, 10 мянган га талбайд үр тариа, тэжээл тариалах ухаалаг газар тариалан бүхий орчин үеийн хөдөө аж ахуйн цогцолборыг бүтээн байгуулжээ.



Тус хөдөө аж ахуйн цогцолбор нь нийт 200 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалт бөгөөд “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд олгогддог хөнгөлөлттэй зээлээс 22 тэрбум төгрөгийн зээл авсан байна. Мөн мах боловсруулах үйлдвэр, үхрийн аж ахуй болон газар тариалангийн тоног төхөөрөмжийг гаалийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан байна

“Agro Expo 2024” олон улсын хөдөө аж ахуй, газар тариалан, ойн аж ахуйн салбарын нэгдсэн хамгийн том үзэсгэлэн нээлтээ хийлээ. Энэхүү үйл ажиллагаанд салбарын бизнес эрхлэгчид, олон улсын байгууллагууд, мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудын төлөөлөл болон БНХАУ, ОХУ, БНСУ, Малайз зэрэг 10 орчим орны нийтдээ 80 гаруй байгууллагуудын төлөөлөл оролцож, өргөн цар хүрээг хамран зохион байгуулагдлаа.

# AGRO EXPO 2024





## Хонины аж ахуй эрхлэгчдийн зөвлөгөөн боллоо



**М**алын чанар үүлдэрлэг байдлыг сайжруулах, мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуй, эрхлэгчдийг чадавхжуулах, дэвшилтэд технологи нэвтрүүлэх зорилгоор Монголын мал зүйч үржүүлэгчдийн үндэсний холбоо, “Хүнсний хувьсгал” ТББ-тай хамтран “Хонины аж ахуй эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг хоёр дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Тус зөвлөгөөнд мал аж ахуйн салбарын эрдэмтэн, судлаач, орон нутгийн мэргэжилтнүүд, эрчимжсэн хонины аж ахуй эрхлэгч, малчдын төлөөллөөс бүрдсэн нийт 260 гаруй хүн оролцлоо.



## Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгийн лаборатори байгуулах төслийн явцын талаар мэдээлэл солилцлоо



**М**онгол Улсын Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгийн лаборатори байгуулахтай холбогдуулан Японы “Шимадзү” корпорацийн төлөөлөлтэй уулзлаа. Уулзалтаар “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих, хүрээлэнгийн лаборатори байгуулах чиглэлээр хамтран ажиллах төслийн явцын талаар мэдээлэл солилцлоо.

Япон Улсын “Шимадзү” корпораци нь ШУТИС-ийн үйлдвэрлэлийн технологийн сургуультай хамтран уг төслийг боловруулсан байна. Төслийн хүрээнд Монгол Улс экспорт, импортын бүтээгдэхүүндээ дэлхийн стандартад нийцсэн, олон улсад итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлт гаргах боломжтой болно. Мөн хүнсний орц, найрлага, шимт бодисын жагсаалт, ном эмхэтгэл гаргахаас гадна лабораториудад ажиллах боловсон хүчнийг бэлтгэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэх юм байна.





## “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөдөлгөөнүүдийг цогцоор нь эрчимжүүлэхээр УИХ-ын ажлын хэсэг байгуулагдлаа



Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны наймдугаар сарын 19-ний өдрийн 42 дугаар тоот захирамжаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” үндэсний хөдөлгөөнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх, бодлого, арга зүй, удирдлагаар дэмжих, хяналт тавих, холбогдох арга хэмжээний болон хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мөн хөтөлбөр хоорондын уялдаа холбоог сайжруулах зэрэг асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай ахалж байна.

УИХ-ын даргын дэргэдэх хөдөө аж ахуйн чиглэлийн үндэсний хэмжээний “Шинэ хоршоо”, “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал” хөдөлгөөний үйл ажиллагааг эрчимжүүлж хяналт тавих, шаардлагатай хууль эрх зүйн орчныг сайжруулах зорилготой ажлын хэсэгт УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, П.Батчимэг, М.Ганхүлэг, Б.Заяабал, Ц.Илэрбат, С.Лүндэг, З.Мэндсайхан, Л.Соронзонболд Р.Сэддорж, А.Ундраа, Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин нар багтсан байна.

Энэ оны 04 дүгээр сараас орон даяар хэрэгжиж эхэлсэн “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөдөлгөөний хүрээнд улсын хэмжээнд нийт 5637 шинэ хоршоо байгуулагдаж, 58000 малчин хоршооны гишүүнээр элсэнэнэс одоогийн байдлаар нийт 13355 малчин 442 орчим тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагджээ. Цаашид хоршооны гишүүдэд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгохтой холбогдуулан зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэн, нөөц санг бүрдүүлж, хоршооны гишүүн малчдад олгосон хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зөрүүг төрөөс хариуцах зэрэг үйл ажиллагааг тасралтгүй, тогтвортой хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана гэдгийг Ажлын хэсгийн ахлагч тодотгов.



### Эдийн засгийн форум: “Хөдөөгийн хөгжил ба хоршоо, эрчимжсэн мал аж ахуй” сэдэвт салбар хуралдаан боллоо

“Хөдөөгийн хөгжил ба хоршоо, эрчимжсэн мал аж ахуй” сэдэвт хуралдаанаар салбарын өнөөгийн нөхцөл байдал, “Шинэ хоршоо” болон “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний уялдаа холбоо, хэрэгжилтийн талаар өргөн хүрээнд хэлэлцлээ.

Тухайлбал, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй байгаль цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг малчдад танилцуулах зорилгоор 140 хоршооны малчдын сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулсан байна.

Мөн залуу малчдыг Өвөр Монголын өөртөө засах орны мал аж ахуйн онцлог, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, малчдын аж амьдралыг танилцуулж туршлага судлуулсан байна. Уг сургалтаар малын хашаа, хороог хэрхэн шийдвэрлэх, өвс, тэжээлийн хангамжийг хэрхэн бүрдүүлж, зөв зохистойгоор малыг тэжээх нь үүсэж болох мал аж ахуйн эрсдэлээс сэргийлэх талаар мэдээлэл хүргэсэн талаар тус салбар хуралдааны үеэр дурдлаа.





## УИХ дахь Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих ажлын хэсэг хуралдлаа

УИХ дахь Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих ажлын хэсгийн тав дахь удаагийн хуралдаан боллоо. Ажлын хэсгийн хуралдаанаар “Хүнсний хувьсгал” “Цагаан алт” “Шинэ хоршоо” зэрэг үндэсний хөдөлгөөнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд хийж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар хэлэлцлээ.

ХХААХҮЯ-аас дээрх хөдөлгөөнүүдийн хэрэгжилт, явцын талаар мэдээлэл өгч, ажлын хэсгийн гишүүд асуулт асууж санал хэлэв.

**Ажлын хэсгийг ахалж буй УИХ-ын гишүүн М.Мандхай “Хүнсний хувьсгал” “Цагаан алт” “Шинэ хоршоо” зэрэг үндэсний хөдөлгөөнүүдийн давхардлыг арилгах, уялдаа холбоог тогтоох, хэрэгжүүлэх арга замын зураглалыг танилцууллаа.**

УИХ дахь Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих ажлын хэсгийн хуралдаанаар дээрх хөдөлгөөнүүдийг хооронд нь уялдуулах, хүрэх үр дүнгээ тодорхой тооцоолж мэдээлэл өгөхийг ХХААХҮЯ-нд даалгав. Мөн “Хүнсний хувьсгал” “Цагаан алт” “Шинэ хоршоо” зэрэг хөтөлбөр хоорондын уялдааг хангах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд илүү анхаарч, боловсролын байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатайг онцлолоо.



## Өндөр ашиг шимт фермерийн аж ахуйг хөгжүүлж, сүүний гарц, нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ



**М**онгол Улсын Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр, Мэргэжлийн сүмо бөхийн 70 дахь их аварга Харүмафүжи Д.Бямбалоржийн үүсгэн байгуулсан “Харүмафүжи сүүний ферм”-д ажиллалаа.

Харүмафүжи аварга Төв аймгийн Баянхангай суманд хөрсний доройтолд орсон 200 га газрыг нөхөн сэргээж, үхрийн тэжээл болох эрдэнэ шиш, судан өвс тариалах ажлаас фермерийн аж ахуйгаа эхлүүлжээ. Тэрээр хүүхдийн сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг дотоодоос бүрэн хангадаг, жишиг болохуйц цогц ферм хөгжүүлэхийг зорьж буй юм. Тус ферм нь нэг үнэнээс өдөрт 35-40 литр сүү саах боломжтой Францын сүүний чиглэлийн 100 гаруй Монбилиард үүлдрийн үхэртэй бөгөөд үхрийн баасыг хуримтлуулж, бордоо болгон ашигладаг буюу уг ферм нь огт хог хаягдалгүй, эко эрчимжсэн мал аж ахуй аж.

Дэлхийн стандарт хангасан эрүүл ахуйн өндөр шаардлага бүхий бүрэн автомат саалтуураар вакум орчинд, агаартай урвалд оруулахгүй байдлаар боловсруулдаг “Пастерийн арга” гэж нэрлэгддэг бага хэмээр халааж ариутгадаг технологиор уг сүүг үйлдвэрлэдэг бөгөөд энэ нь түүхий сүүний өөрийнх нь амт, чанар, шимт байдлыг хадгалдагаараа онцлогтой аж.

Монгол Улсын хэмжээнд сүү, сүүн бүтээгдэхүүний 206 үйлдвэр, цех 77 хөргөлтийн төв үйл ажиллагаа явуулж, тэдгээрт нийт 1680 гаруй хүн ажиллаж байна. Үүнээс сүү боловсруулах 10 үйлдвэр олон улсын чанарын болон хүнсний аюулгүй байдлын тогтолцоо нэвтрүүлсэн /ISO 9000, ISO 22000, HACCP, тетрапак/ байна.

## Генийн дараалал тогтоох NGS технологийг Хөдөө аж ахуйн салбарт нэвтрүүлэх нь өндөр ач холбогдолтой

**М**онгол Улсын Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр генийн дараалал тогтоох NGS технологийг Монгол Улсад нутагшуулж буй Есөн мед ХХК-ийн төлөөллийг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар генетикийн дараалал тогтоох NGS технологийн Хөдөө аж ахуйн салбарт хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар мэдээлэл өгч, харилцан санал солилцлоо. Уг технологийг олон улсад эрүүл мэндийн салбар төдийгүй хүнс, хөдөө аж ахуйн салбарт хүнсний чанар, ургамал, үр тариа, малын үр шим сайжруулах чиглэлд өргөнөөр ашигладаг байна.



## Монгол Улс дотоодын болон импортын давсыг иоджуулан хүнсэнд хэрэглэхийг НҮБ-аас зөвлөлөө

**М**онгол Улсын Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар Монгол Улсад иоджуулсан давсны хэрэглээг нэмэгдүүлэх, импортын болон дотоодод үйлдвэрлэж буй давсыг иоджуулах асуудлыг хөндөн хэлэлцсэн юм.

Манай улс 1996 онд “Иод дутлын эмгэгтэй тэмцэх” хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн. Үүнээс хойш айл өрхийн иоджуулсан давсны хэрэглээг нэмэгдүүлж, улмаар иод дутлын эмгэгийн тархалт 4 дахин буурсан байдаг. Харин энэ асуудал өнөөдөр эргэдэг сөхөгдөж эхэлснийг НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөөлөл хэлж байна. Учир нь сүүлийн жилүүдэд иргэд иоджуулаагүй жамц давс түлхүү хэрэглэдэг болсноос гадна хүн амын ерөнхий хооллолтын дэглэмд өөрчлөлт орсноор иод дутлын эмгэгийн тархалт нэмэгдэх хандлагатай болсон байна. Тиймээс иод дутлын эмгэгээс урьдчилан сэргийлж дотоодын болон импортын давсыг иоджуулан хүнсэнд хэрэглэхийг НҮБ-аас зөвлөлөө.



## “Хүнсний хувьсгал”-ын хэрэгжилтэд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо анхаарч ажиллана

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг цаашид улам бүр амжилттай хэрэгжүүлэхийн тулд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо маш чухал юм. Иймд тус хөдөлгөөний хүрээнд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны бүрэлдэхүүнд өнгөрсөн хугацаанд хийгдсэн ажлууд болон цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа танилцууллаа.

Тодруулбал, малыг эрүүлжүүлэх, стандартжуулах, мах экспортлох болоод ард иргэдээ чанартай, хямд махаар хангах талаар хэлэлцлээ. Мөн хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, аюулгүй байдалд анхаарах, хяналт тавих зэрэг өргөн хүрээнд санал солилцож, хийгдэж буй ажлуудын хэрэгжилтэд илүүтэй анхааран хамтран ажиллахаа хоёр тал илэрхийллээ.




## Дулаан алдахгүй жилийн дөрвөн улирлын турш тариалалт хийх боломжтой ухаалаг хүлэмж ашиглалтад орлоо

“Хойд бүсэд зохицсон ухаалаг хүлэмжийн загвар аж ахуйг хөгжүүлэх төсөл”-ийн нээлт боллоо. Тус үйл ажиллагаанд Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр зэрэг албаны хүмүүс оролцлоо.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын санхүүжилтээр Хөдөө Аж Ахуйн Их Сургуультай хамтран 2021 оноос эхлэн хэрэгжүүлж буй уг төслийн хүрээнд манай орны эрс тэс уур амьсгалд тохиромжтой бөгөөд жилийн дөрвөн улиралд тариалалт хийх боломжтой дэвшилтэт технологийн дагуу өвөл, зуны найман хүлэмжийг жишиг загвараар барьж ашиглалтад оруулжээ.



## “Хүнсний хувьсгал” Мэргэжлийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүдийн VII хуралдаанд ХХААХҮ-ийн сайд Ж.Энхбаяр оролцлоо



“Хүнсний хувьсгал” Мэргэжлийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүдийн VII хуралдаан зохион байгуулагдлаа. Энэ удаагийн хуралдаанд ХХААХҮ-ийн сайд Ж.Энхбаяр, ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн болон бусад албаныхан оролцож, Засгийн газраас хүнс, хөдөө аж ахуйн салбарт хийгдэх бодлого, шийдвэрүүдийг танилцууллаа.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын холбоодын нэгдэл, салбарын төлөөллүүд багтсан “Хүнсний хувьсгал” Мэргэжлийн холбооны удирдах зөвлөлийн гишүүд “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх талаар санал хүсэлтээ салбарын сайдад илэрхийлж, мэдээлэл солилцлоо. Мөн “Хүнсний хувьсгал” Мэргэжлийн холбооны өнгөрсөн хугацаанд хийсэн төлөвлөгөөт ажлын тайлантай танилцсан юм.

## Хүнсний аюулгүй байдлын зөвлөл хуралдаж, зөвлөмж гаргалаа

Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн хуралдаан 2024 оны наймдугаар сарын 30-ны өдөр болов. Хуралдааныг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр ахалж, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр болон бусад албаныхан оролцлоо.

Хуралдаанаас дараах зөвлөмж гаргалаа:

- Бүх төрлийн малын махны экспорт, импортод 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байх;

- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Сагааннуур, Боршоо, Арцсуурь боомтоор улаанбуудайн баяжуулсан болон баяжуулагүй гурилыг, бусад боомтоор улаанбуудайн баяжуулсан гурилыг тус тус импортлох;

- Мах, махан бүтээгдэхүүний экспортын зах зээлийг тэлэх зорилгоор худалдааны түнш орнуудтай дотор мах, дайвар бүтээгдэхүүн экспортлох үеийн мал эмнэлэг, хорио цээр, ариун цэврийн шаардлагын тухай протокол тохирох ажлыг эрчимжүүлэх талаар зөвлөмж гаргаж, холбогдох сайд, агентлагийн дарга нарт хүргүүлжээ.



## Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын захирамжийн дагуу байгуулагдсан “Хүнсний хувьсгал”-ын дэргэдэх эрдэмтдийн зөвлөлийн IV хуралдаан боллоо

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын 125 тоот захирамжийн дагуу байгуулагдсан “Хүнсний хувьсгал”-ын дэргэдэх эрдэмтдийн зөвлөлийн IV хуралдаан боллоо. Хуралдаанаар пестицидийн талаар өргөн хүрээнд авч хэлэлцсэн бөгөөд энэ дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх Н.Хүрэлбаатар өөрийн санал бодлоо илэрхийллээ. Мөн хуралдааныг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр даргалж, пестицидийн асуудал, түүний хэрэглээ, хяналт шалгалт зэргийг хэрхэн шинжлэх ухаанч байдлаар шийдвэрлэх талаар эрдэмтэд, судлаачдын байр суурь, дүгнэлтийг тодрууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд шийдэгдэх чухал ажлуудын нэг бол хүнсний аюулгүй байдлын асуудал юм. Хүн амыг эрүүл, аюулгүй, чанарын баталгаатай хүнсээр хангаснаар улс үндэсний дархлаа цаашлаад үндэсний аюулгүй байдал батжин тогтох учиртай. Иймд Монгол Улсад төдийгүй дэлхий нийтийн асуудал болоод буй хүнсний аюулгүй байдлын талаар эрдэмтэн, судлаачид ийнхүү хуралдлаа. Нэн ялангуяа хүнсний аюулгүй байдлын нэг чухал хүчин зүйл болох химийн бодис, хорт бодис пестицидийн талаар нарийвчлан авч үзсэн юм.



## “Евро-Азийн өндөглөгч тахианы аж ахуйн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага” сэдэвт форум зохион байгуулагдлаа

“Түмэн шувуут” ХК үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн хүрээнд “Евро-Азийн өндөглөгч тахианы аж ахуйн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага” сэдэвт форум зохион байгуулагдлаа.

Энэхүү үйл ажиллагаанд АНУ, Итали, ОХУ, БНХАУ зэрэг улсуудын томоохон компаниудын төлөөллүүд оролцон, шинэ инновац туршлагаа хуваалцаж, Евро-Азийн өнөөгийн байдал, чиг хандлага, ирээдүйн талаар олон талт мэдээллийг хуваалцав.



## “Хүнсний хувьсгал”-чид

**Т**өр, засаг нь ард иргэд, баялаг бүтээгчдээ бүх талаар дэмжиж, бодлого нь тодорхой, дэмжлэг нь оновчтой, санхүүжилт нь хүртээмжтэй байж, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулж, сэтгэл гарган хамтран ажиллаж байж монголчууд бид өрх бүлээрээ хүнс үйлдвэрлэгч, улс орноороо хүнс экспортлогч болно.

Энэ зорилгыг биелүүлэхэд хамгийн чухал үүрэг гүйцэтгэж буй хүмүүс бол хөдөлмөрч, аж ахуйч иргэд юм. Тэд бол жинхэнэ “Хүнсний хувьсгалчид” төдийгүй төрийн тэргүүний санаачилгыг биелүүлэх тэргүүн эгнээний хүмүүс.



### П.Очирбат:

“Мандалговийн алим”  
брэнд бий болгох хүсэл  
тэмүүлээр энэ жил 1100  
алимын мод тарьсан

**Г**эр бүлийнхээ хамтаар говийн хөрсөнд тарьсан алимаар Дундговь аймгийн хэрэглэгчдэд хэдийн танил болсон нэгэн эрхэм бол “Арвин их сан” ХХК-ийн захирал Пүрэвжавын Очирбат юм.

Тэрбээр гэр бүлийнхээ хамт алимын аж ахуй эрхлэн “Мандалговийн алим” брэнд бий болгох зорилго өвөрлөн бизнест хөл тавьсан юм. Түүний гэр бүл, эрхэлж буй бизнес, залуу хүний хүсэл мөрөөдлийн талаар тодрууллаа.

➤ Говийн хөрсөнд алим, жимс тарьж ургуулах боломж байгааг нутгийнхандаа мэдрүүлсэн хүмүүсийн нэг нь та. Хэзээнээс алим тарьж эхэлсэн бэ?

- Анх 2019 онд алимын 10 суулгац хашаандаа суулгаад гурван жилийн дараа үр жимсээ өгсөн. Үнэхээр урамтай ургаж, аймгийн хөрсөнд алим жимс тарьж болох юм байна гэсэн их итгэлийг надад төрүүлсэн. Өнгөрсөн жил тоог нь нэмж, 50 гаруй алимын мод тарьсан. Сүүлд тарьсан моднууд маань ирэх жилээс жимсээ өгнө.

Нэг модноос 20-35 кг алим гардаг. Тэгэхээр 2021 оноос хойш жилд 200 орчим кг алим авч, тодорхой хувийг нь хэрэглэгчдэдээ амсуулсан. Амт чанарын хувьд үнэхээр тансаг даа.

➤ Энэ жил алим тарих сонирхлоо аж ахуй болгон өргөжүүллээ. Энэхүү ажлаа танилцуулбал?

-Алим тарьж ургуулах сонирхлоо аж ахуй болгон өргөжүүлэх санаагаа энэ жил эхэлж, маш их хөдөлмөрлөлөө. Хөдөлмөр чинь өөрөө ид шид юм байна. Нийт хоёр га талбайг хашаажуулж, талбайдаа 1100 ширхэг алимын мод тарьсан.

Улсын Их Хурлаас баталсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” төлөвлөгөөний дагуу ХХААХҮ-ийн сайдын шийдвэрээр Дундговь аймагт жимс, жимсгэний төрөлжсөн талбай байгуулах, Улаанбаатар хотоос шилжин ирсэн өрхөд бизнес эрхлэх зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгохоор болж, төслийн уралдаан зарласан. Энэ уралдаанд манай “Арвин их сан” ХХК “Мандалговийн алим-Арвин их сан” төсөл боловсруулан оролцож дэмжлэг авсан. Тэгээд төслөө амжилттай хэрэгжүүлж эхэллээ. Энэ жил бороо хуртай, сайхан зун болсон учраас ургалт маш сайн байна.



► **1100 ширхэг модноос хэдэн кг жимс авахаар төлөвлөж байна вэ?**

- Нас бие гүйцсэн нэг модноос 35 кг алим авах тооцоо бий. гурван жилийн дараагаас жимсээ өгч эхэлнэ. Тэгэхээр ирээдүйд алим талбайгаасаа 35 тн алим хураах боломжтой.

Энэ бол үнэхээр боломжийн үр дүн. Аймгийнхаа зах зээлийг хангаад Улаанбаатар болон Өмнөговийн хэрэглэгчдэд нийлүүлэх боломжтой гэж бодож байгаа.

► **Гэр бүлээ танилцуулаач, төрийн албанд ажиллаж байгаад алим аж ахуй эрхлэх шийдвэр гарган, бизнест хөл тавьсан гэхээр их сонирхолтой санагдаж байна?**

- Миний хувьд төрийн албанд 15 жил ажиллаж байгаад 2022 онд бизнес эрхлэх шийдвэрээ гаргасан.

Эхнэрийг маань Ганхуягийн Жавзмаа гэдэг. Төрийн албанд зургаан жил ажилласан. Бид хоёр хоёулаа аймгийн ЗДТГ-г мэргэжилтэн хийж байсан юм. Эхнэр маань 2023 оноос бизнес эрхэлж эхэлсэн.

Бид хоёрын хувьд эхлээд алим тарих боломжтой гэдгийг мэдэрчихсэн учраас шийдвэр гаргах нь цаг хугацааны л асуудал байсан байх. Ажлаасаа гараад кофе шоп ажиллуулж байсан. Мөн хүнсний дэлгүүр ажиллуулдаг. Мэдээж төрийн байгууллагад ажиллаж байгаад хувийн хэвшилд хүч сорино гэдэг маш их зориг гаргаж байгаа хэрэг. Тэр тусмаа гэр бүлийн хоёр хүн хоёулаа ингэж шийдэх нь нэг талаас эрсдэлтэй ч байж магадгүй.

Гэхдээ бид хоёрын хувьд илүү том мөрөөдөл байсан учраас энэ шийдвэрийг гаргасан. Яагаад говьд алим аж ахуй эрхэлж болохгүй гэж. Бид хоёр “Мандалговийн алим” гэсэн брэнд бий болгох их зорилго, их хүсэл мөрөөдөлдөө хөтлөгдөөд өнөөдөр түүнийхээ бараг л ихэнх хувийг амжуулаад явж байна. Одоо багахан хугацааны дараа нутгийнхаа олон түмнийг Мандалговийн алимаар хангана.

Манай нутаг онцлогтой. Байгаль цаг уурын хувьд нартай, дулаан өдрийн тоо нь олон, өдөрт нар тусах хугацаа урт болоод ч тэр үү манай алим амт час хийсэн, илүү витаминлаг байдаг. Хүн бүр л алимг маань авахыг хүсдэг ч одоохондоо бидний авч байгаа ургацын хэмжээ бага. Тиймээс л ийм сайхан алимг илүү олон хүнд амсуулахсан, хэрэгцээг нь хангахсан гэсэн хүсэл бидэнд байдаг юм. Ургалтын хувьд ус л байвал говийн хөрсөнд алим их сайхан ургадаг.

Цаашлаад манай алимг зэргэлдээх аймгийн хэрэглэгчид ч хэрэглэх, бүр экспортод гаргахыг ч үгүйсгэхгүй. Энэ бол бид хоёрын мөрөөдөл юм. Талбайдаа үрэл жимсний мод, бэсрэг алим дөрвөн сорт, том алим дөрвөн сорт тарьсан.

► **Говийн нөхцөлд алим тарьж ургуулахад юуг анхаарах вэ?**

- Эхний ээлжид алим суулгацаа зөв сонгох, болж өгвөл

эх орны хөрсөнд дасан зохицсон, өвчлөлгүй, хөгжил сайтай суулгацыг олж тарих хэрэгтэй.

Хоёрдугаарт, суулгацны нүхийг нь томхон хэмжээтэй, болж өгвөл 1x1 метр харьцаатай ухвал сайн.

Дараа нь хөрсөө сайн боловсруулж бэлтгэх нь чухал байдаг. Бууц, элс, хар шороог тэнцүү хэмжээтэй хольж хийх ба сийрэг байлгах, чийгшил хадгалах зорилгоор модны үртэс хийж болно.

Манай иргэдийн хувьд суулгацаа хэт гүнд суулгаж, ургах чадварыг нь багасгах тал анзаарагддаг. Залгуур хэсгийг нь газрын түвшнээс жоохон дээш 2-3 хуруу орчим тарих хэрэгтэй. Модны тогоог 60-100 литр ус багтах хэмжээтэй томхон хийж өгвөл сайн.

Тэгээд усалгаандаа сайн анхаарах нь чухал. Алим мод ус чийг, гэрэл, наранд маш дуртай ургамал. Манай говийн нөхцөлд хүчтэй салхи их гардаг учраас салхинаас хамгаалж, нөмөр, нөөлөг хийх зайлшгүй шаардлагатай. Хашаандаа тарих гэж байгаа бол хашаа, байшингийн нөмөрт таривал сайн ургадаг.

► **Таны эрхэлж буй энэхүү бизнесийн үйл ажиллагаа Монгол Улсын Засгийн газрын “Тэрбум мод”, “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн болон “Дундговь ноогоорууль” дэд хөтөлбөрийн зорилго, зорилттой уялдаж байна. Энэ талаар та өөрийн бодлоо хуваалцана уу?**

-“Хүнсний хувьсгал” гэдэг маань өөрсдөө хүнсээ бэлтгэж, гэр бүлээрээ баталгаатай, эрүүл хүнс хэрэглэхийг хэлж байгаа гэж ойлгож байгаа. Бид ихэнхдээ импортоор оруулж ирсэн алим, жимсийг хэрэглэдэг. Хэн, хаана, ямар хөрсөнд хэрхэн тарьж ургуулаад, ямар зам туулж бидний гар дээр ирж байгааг мэдэхгүй учраас үүнийг баталгаатай гэж хэлэхэд хэцүү.

Харин нутгийнхаа хөрсөнд, өөрсдийнхөө итгэл сэтгэл, хөдөлмөрөө шингээн тарьж ургуулсан хүнс гэдэг бол жинхэнэ эко хүнс. Тиймээс улс, аймгаас дэвшүүлж байгаа зорилттой уялдаж байна.

Аймаг, орон нутаг гэлтгүй айл өрх бүр хашаандаа алим мод тарьж ургуулбал энэ бодлого жинхэнэ утгаараа хэрэгжинэ гэж бодож байна. Тиймээс нутгийнхаа бүх иргэнд хашаандаа алим, жимсээ тарьж ургуулан “Мандалговийн алим” гэсэн брэндтэй болохыг уриалж байна.

► **Ярилцсанд баярлалаа. Алим аж ахуйгаа өргөжүүлэн, “Мандалговийн алим” брэндийг түмэн олны хэрэглээнд хүргэх хүсэл мөрөөдлөө биелүүлээрэй!**

Ярилцсан: Д.Алтантогос



## **Б.Батхүү:**

Монгол ангус үхэр дан бэлчээрийн маллагаатай хэр нь үүлдрийнхээ үндсэн ашиг шимт чанарыг бүрэн хадгалдаг



**Д**орнод аймгийн Баяндун сумын иргэн, “Монгол Ангус үржүүлэг” ХХК-ийн захирал **Б.Батхүүтэй ярилцлаа. Түүний хувьд сүүлийн 20-иод жил малын үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр судалгаа хийж, цөм сүрэг үүсгэн, ирээдүйд дэлхийн стандартад нийцсэн стэйкний махыг экспортод гаргах зорилготой явна.**

► **Намаржаа тавлаг сайхан уу? Буриад зон олон хадландаа гарсан намар цагаар Та бид хоёр уулзаж байна. Өвөлд бэлэн үү?**

- Сайхан намаржиж байна. Манай буриадууд хадлан тэжээлээ сайтар базаадаг уламжлалтай зон олон. Өнгөрсөн өвлийн цас зуднаас хатуу сургаж авч, энэ жилийн бэлтгэлийг эртнээс эхэлж, ахиухан өвс авах зорилготой хадландаа гараад байна.

► **Сүүлийн жилүүдэд баруун талаас манай аймгийг чиглэсэн отор нүүдэл нэмэгдэж, олон малын хөлд бэлчээр талхлагдах эрсдэл бий боллоо. Манай улс 72 сая малтайгаас тал хувь нь эр мал гэсэн тооцоо судалгаа ч бий. Малын чанар тоо толгойд анхаарахын тулд үүлдэр угсааг сайжруулах шаардлага тулгарч байна. Энэ тал дээр Та бодит ажил хийж яваа хүн?**

- Дорнодын байгаль цаг уурын таатай нөхцөл, бэлчээрийн хүрэлцээ, малын таваарлаг байдал зэргийг харгалзан дэлхийн шилдэг үүлдрийн нэг Абердин ангус үхрийг үржил селекцийн аргаар нутагшуулах ажлыг 18 жил хийж байна. Дэлхий дээр 990 үүлдрийн үхэр бий гэсэн судалгаа байдаг. Эдгээрээс хамгийн олон буюу 41 улсад нутагшуулсан нь ангус үүлдэр юм. Энэ үхэр байгаль цаг уурын -+40 хэм буюу ямар ч нөхцөлд дасан зохицох чадвар, бэлчээр ашиглалт сайтай, төрөлхийн мухар хэвшилтэй, зүсний хувьд хар, улаан, төрөх үеийн

хүндрэлгүй, эдгээрээс гадна хоногийн нэмэгдэл жин, өндөр зэргийг харгалзан ангус үүлдэрээр нутгийн монгол үхрийн махан ашиг шимийг нэмэгдүүлэх үржлийн ажил эхлүүлсэн.

Одоогийн байдлаар үржлийн аж ахуйн цөм сүргийг 3, 4 дүгээр үе /F3, F4/-ийн үхрээр бүрдүүлж, бэлчээрийн үхрийн үндсэн сайжруулагчаар 18 аймгийн 30 суманд захиалгаар нийлүүлээд байна. Ер нь үржлийн ажлыг өргөжүүлж, Дорнод аймагтаа махны брэнд үхэр гаргах тал дээр судалгааны ажил хийж байгаа юм. Бид үүнийг хийж чадвал Монголдоо төдийгүй дэлхийд танигдсан махны чиглэлийн брэнд үхэртэй болох боломж бий гэж хардаг шүү. Саяхан л гэхэд ӨМӨЗО-ы Хөлөнбуйр аймгаас олон тоогоор тугал авах захиалга ирсэн. Энэ нь махны үхрийн эрэлт хэрэгцээ хаа сайгүй байгааг харуулж байна.

► **Мал, махны экспортын асуудалд манай улсын нутаг дэвсгэр малын гоц халдварт өвчний голомттой, эрүүлжүүлэх шаардлагатай тухай яригддаг ч ямар нэгэн дэвшил өөрчлөлт гарахгүй өнөөдрийг хүрч байна. Гэтэл та сая тугал амьдаар нь экспортод гаргах тухай ярилаа. Ямар нэгэн гарц гаргалгаа бий хэрэг үү?**

- Бичиг баримтаа хөөцөлдөөд бүтэл муутай л байна. Ер нь бол хамгийн багадаа гурван жилийн хугацаанд А зэрэглэлийн гоц халдварт өвчин гаргахгүй сэргийлж, үүнийгээ олон улсад зарласны дараа хянах магадлагааны хугацааг дуусгаж байж хилээр мал мах гаргах ёстой юм байна. Хуульд хамгаалагдсан аж ахуй, хамгаалагдсан бүс гэдэг нэр томъёо бий. Бүс битгий хэл ганцхан аж ахуйг ч хамгаалагдсан аж ахуй болгох боломжтой. Суман дотроо хамгаалалтын бүсийн дэглэмээ сахиж чадах юм бол хажуу айлын мал гоц халдварт өвчин туссан байсан ч хамаагүй хамгаалагдсан бүсээс гаргах боломжтой юм. Мал эмнэлгийн салбар үнэнд гүйцэгдэж байна шүү дээ. Нэг үе малын өвчин гармагц орон даяар зарлаж, вакцинжуулдаг



хэдий ч өвчнийг бүрмөсөн арилгаж чадахгүй явсаар ирсэн. Одоо ч дийлэхээсээ нэгэнт өнгөрөөд харсан ч хараагүй юм шиг байх болсон. Тэгэхээр энэ нь өөрөө мал, мах экспортлоход том саад болж байна.

**» Монгол малыг эрлийзжүүлэх нь буруу гэсэн байр суурьтай хүн цөөнгүй байдаг. Энэ асуудалд мэргэжлийн хүний хувьд ямар бодолтой байдаг вэ?**

- Манай суманд одоогоор арав орчим малчин айл хамтарч мянга гаруй үхрийг судалгаанд хамруулж, үүлдэр угсааны ажил хийж байгаа. Бид нутгийн брэнд мах гаргаж авах зорилготой. Энэ датаг аймгийн хэмжээнд биш гэхэд Улз гол дагасан гурван сум эсвэл урд талын сумдад хувилахад л бэлчээрийн даац, эдийн засгийн хувьд маш том боломж бий болно шүү. Үржлийн биотехнологийн ямар ч мэдлэггүй хүмүүс ийм мэдээллийг их сэвдэг л дээ. Мэргэжлийнхэн бол үүнийг ойлгоно. Энгийнээр тайлбарлая. Аливаа малын ашиг шим өндөр байх тусмаа тэжээллэг болон тавлаг байдлыг илүү шаарддаг. Өвлийн улиралд өвс тэжээлээ идэх хугацаа нь богино, эрс тэс уур амьсгалаас шалтгаалаад энергийн алдагдал их байдаг. Алдсан энергиэ хоол тэжээлээр нөхөж авах ёстой шүү дээ. Тэр тэжээлийг нь өгч чадахгүй бол турж эцдэг, энэ утгаар нь эрлийз малыг тэжээл өгч байж онд ордог хэврэг гэж хүмүүс ойлгодог. Аливаа малыг эрлийзжүүлэн сайжруулахдаа сайжрагч малын тэсвэр тэвчээр, бусад давуу шинжийг хадгалж, зөвхөн сайжруулахыг хүссэн ашигт чанарыг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Манай үржүүлж байгаа монгол ангус үхэр дан бэлчээрийн маллагаатай хэрнээ үүлдрийнхээ үндсэн ашиг шимт чанарыг бүрэн хадгалсан байдаг. Энэ олон жил би юунд зорьсон бэ гэхээр өвөл тэжээлдэггүй, битүү байранд ордоггүй, бэлчээртээ хэвтээд, тэндээ төллөдөг үхэр гаргахыг л хичээсэн. Монгол малтай адил тэсвэртэй хэр нь илүү жинтэй, чацархаг. Манай ангусууд ноднин өвлийн цас зуданд хөдөө бэлчээртээ л өвөлжсөн. Махны

чиглэлийн үхрийн мах нь булчин эсийн хооронд өөх алаглаж сууснаараа махны чанарыг дээшлүүлдэг.

**» Танай аж ахуйд ургасан жимсний моднууд нүд булаам харагдаж байна. Орон нутагт үхэр малаас гадна жимс, ногооны тариалан эрхлэх нь өөр төрлийн аж ахуйг хөгжүүлэх бас нэг чухал алхам байж болох нь ээ?**

- Манайх 2019 оноос эхэлж хашаандаа 33 төрлийн 500 гаруй мод тарьж, гурав дахь жилээсээ жимсээ өгч эхэлсэн. Энэ жил алимын нэг модноос 25-30 кг алим хураасан. Ер нь айлууд алимын 10 модтой байхад л өрхийн хэрэгцээгээ хангаад илүүг нь худалдан борлуулахад чамлахааргүй мөнгө олох боломжтой. Айлууд модноос гадна өрхийн орлогоо нэмэгдүүлэх тахиа, зөгийний зэрэг туслах аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэх хэрэгтэй. Энэ тал дээр орон нутгийн бодлого шийдвэр гардаг байх нь чухал гэж боддог. Өрх бүр ашиг орлоготой, хүн бүр үйлдвэрлэгч болж байж сум орон нутгийн эдийн засгийг тэлэх суурь бүрдэнэ. Айл өрх, албан байгууллага бүр хашаандаа жимсний болон гоёлын мод тарьснаар сумын өнгө үзэмжийг сайжруулж, орчны тоосжилт, дуу чимээг багасгахаас гадна жимсний модноос өрхийн орлогоо нэмэгдүүлэх бүрэн боломж бий.

*Ярилцсан: Д.Дэлгэрмаа*





## Ерөнхийлөгчийн “Булган сүүл”-тэй санаачилга



**Х**үнс, хөдөө аж ахуй бол маш өргөн цар хүрээтэй, олон асуудлыг багтаасан салбар. Монгол Улсын Ерөнхийлөгч “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг санаачлан эхлүүлсэн нь “мөсөн уулын орой” нь байсан гэдгийг цаг хугацаа харууллаа. Тус хөдөлгөөн өрнөснөөр үндэсний үйлдвэрлэгч, баялаг бүтээгчдэд олон давуу тал бий болж, гол тулгамдсан асуудлууд шийдэгдэж байгаа ч хүртээмжийг нэмэгдүүлэх нь чухал. Тухайлбал бага хүүтэй, урт хугацаатай хөнгөлөлттэй зээлэнд газар тариалангийн салбарт хамгийн их үр дүн гарсан бол мал аж ахуйн салбарт хамгийн бага өгөөжтэй байна. Малчид барьцаа хөрөнгөгүй, тогтмол орлогогүй, малын гаралтай бүтээгдэхүүн хямд үнэтэй байгаа тул зөвхөн энэ асуудлыг шийдэхэд чиглэсэн төрийн бодлого байх хэрэгтэй нь үүнээс харагдана.

Нөгөө талдаа малын гаралтай түүхий эдийг боловсруулах хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх шаардлага тулгарсан.

1990 оноос манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих нийгмийн цогц өөрчлөлт, шинэчлэлтийг өрнүүлж эхэлсэн. Энэ цаг үед олон аж үйлдвэрүүд, үйлдвэр комбинатуудын хэвийн үйл ажиллагаа доголдож, олон мянган монголчууд ажлын байраа алдсан байдаг.

Аж үйлдвэрлэлийн салбар тэр дундаа хөнгөн үйлдвэрлэлийн салбар 2000 оноос сэргэж байгаа хэдий ч

импортоос өндөр хамааралтай, эмзэг хэвээр байна.

“Хөнгөн үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний экспорт манай улсын нийт экспортын дөнгөж 6 хувьтай тэнцэж байна. Харин нөгөө талдаа хүнс, гутал, хувцас, арьс, савхин эдлэлээс эхлээд хөнгөн үйлдвэрлэлийн шинжтэй бараа бүтээгдэхүүн гадаадаас худалдан авахад жилд ойролцоогоор 3 тэрбум орчим ам.долларыг монголчууд бид гадагшаа урсгадаг. Олон зуун жилийн нүүдлийн мал аж ахуйн соёлтой, 70 гаруй сая малтай манай улс малын гаралтай түүхий эдээ бүрэн боловсруулж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг үүнээс харж болно.

Ганцхан жишээ хэлэхэд Монгол Улс жилдээ 38 мянган тонн хонины ноос бэлтгэж байгаа ч үүний 75 хувийг нь нэмүү өртөг шингээлгүй зөвхөн угаагаад экспортолж байна. Судалгаанаас харахад хэрэв хонины ноосоо дотооддоо бүрэн боловсруулж чадвал энэ салбарын орлого 5-6 дахин нэмэгдэх боломжтой юм.

Мөн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө эрчимжиж, ган зудын давтамж жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь бэлчээрийн мал аж ахуйд суурилсан манай улсын хүнс, хөдөө аж ахуйн салбар цаашид тогтвортой хөгжих, орон нутгийн иргэд, малчдын орлого өсөхөд томоохон эрсдэл, хязгаарлалт болж байна.

Дэлхийн Банкны судалгаагаар манай улсад гадаадын хөрөнгө оруулалт татах боломжтой тэргүүлэх салбаруудаар ноолуурын үйлдвэрлэл, мах боловсруулах үйлдвэрлэл, эрчимжсэн фермерийн аж ахуй түүн дотроо сүү, сүүн бүтээгдэхүүн, сүүний чиглэлийн эрчимжсэн фермерийн аж ахуйг нэрлэсэн байдаг.

Гэвч малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанар хангалтгүй, малын өвчин, малын гарал үүсэл тодорхойгүй, вакцинжуулалт хангалтгүй байгаа зэрэг нь хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжих боломжийг хааж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгч хөдөө аж ахуйн салбарын гол амин сүнс болсон мал аж ахуйн салбарт дорвитой арга хэмжээ авах ёстой гэж үзэн “Цагаан алт”



хөдөлгөөнийг эхлүүлж байна.

Тус хөдөлгөөний хүрээнд дараах асуудлуудыг онцгой анхаарч ажиллана. Үүнд:

- Салбарын эрх зүй, санхүү, татвар, даатгалын таатай орчныг бий болгох;
- Байгаль орчин, мал амьтанд ээлтэй, өндөр чанартай түүхий эд бэлтгэх болон малын гарал үүсэл, чанарын мөшгөх тогтолцоог хөгжүүлэх;
- Үйлдвэрлэлийн хүчин чадал, ашиглалтыг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;
- Хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадавхижуулах, давтан сургах;
- Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зэрэг үйл ажиллагаанд анхаарна.

**Өөрөөр хэлбэл “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт” гэх хоёр үндэсний хөдөлгөөн манай орны хөдөө аж ахуйн салбарыг богино хугацаанд, өндөр үр дүнтэй хөгжүүлэх ТӨРИЙН ТЭРГҮҮНИЙ ХОС БОДЛОГО болон өрнөх юм.**

Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг дэмжих төрийн бодлогын буухиа үүгээр тасраагүй бөгөөд Засгийн газар хоршоо байгуулж, хоршоонд нэгдсэн малчдад хөнгөлөлттэй зээл олгох шийдвэрийг гарган, “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийг 2024 оны дөрөвдүгээр сараас хойш орон даяар хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монголбанк болон арилжааны долоон банктай хамтран жилийн зургаан хувийн хүүтэй, 50 хүртэлх сая төгрөгийн зээл малчдад олгож буй. Уг “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөр таван жилийн хугацаанд хэрэгжих юм.

Улсын хэмжээнд 5637 хоршоо шинээр байгуулагдаж, 58 мянган малчин хоршооны гишүүнээр элссэн байна. Шинэ хоршоо” хөтөлбөрт нэг жилд 500 тэрбум төгрөг төсөвлөсөн бөгөөд одоогийн байдлаар 14,381 малчны 3,467 хоршоонд 495 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Монгол Улсын Ерөнхий Сайд Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг танилцуулж, “ХУРДАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” гэрээг гурван нам байгуулан, Засгийн газрын

2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Улсын Их Хуралд өргөн барьсан.

Тус хөтөлбөр бүхэлдээ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, намуудын мөрийн хөтөлбөрт туссан онцлог заалтуудыг нэгтгэж, хөгжлийн тулгамдсан асуудлуудыг хурдтай шийдвэрлэх, олон жил улс төржин гацсан төслүүдийн зангилааг тайлахад чиглэгдсэн гэдгийг онцолж байв.

Мөн манай улсын гол экспортын бүтээгдэхүүн болсон нүүрсний ашиглалтын цаг хугацаа дуусахад 10 хүрэхгүй жил үлдэж байгаа тул эдийн засгийн төрөлжилтийг зоригтой хийхээр төлөвлөжээ. Засгийн газраас дөрвөн жилд, дөрвөн бүлэг, дөрвөн үндсэн чиглэл, дөрвөн зорилготой, нийт 577 багц үйл ажиллагаатай хөтөлбөрийг танилцуулсан юм.

Засгийн газраас Бүс бүрийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувьд төрөлжсөн болон дэд тэргүүлэх чиглэлтэй байхаар хөтөлбөрт тусгажээ.

- Хангайн бүсийг “Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн, хот байгуулалтын дэд бүс”,
- Баруун бүсийг “Эрчим хүчний төрөлжсөн, байгалийн аялал жуулчлалын дэд бүс”,
- Хойд бүсийг “Байгалийн аялалын жуулчлалын төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс”,
- Говийн бүсийг “Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний дэд бүс”,
- Төвийн бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс”,
- Зүүн бүсийг “Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн, эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс” болгон хөгжүүлэх нь тохиромжтой гэж үзсэн бөгөөд энэхүү хөтөлбөр “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрүүдтэй нягт уялдаж хэрэгжинэ.

Хууль тогтоох байгууллага ч мөн адил гар нийлэн ажиллаж, Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 42 дугаар тоот захирамжаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” үндэсний хөдөлгөөнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх, бодлого, арга зүй, удирдлагаар дэмжих, хяналт тавих, холбогдох арга хэмжээний болон хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мөн хөтөлбөр хоорондын уялдаа холбоог сайжруулах зэрэг асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулаад байна. Уг ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай ахалж буй.

Ийнхүү ЕТГ, ЗГ, УИХ нэг зорилгод төвлөрч, үндэсний хэмжээний дээрх гурван хөдөлгөөний хэрэгжилт, үр нөлөө, уялдаа холбоог эрчимжүүлснээр цаашид нэмүү өртгийн сүлжээг цогцоор нь тодорхойлохоос гадна эдийн засгийг төрөлжүүлэх оновчтой шийдэл болох юм.

*Сэтгүүлч Б.Урантуяа*

**ХҮНСНИЙ  
ХУВЬСГАЛ 5**

Сэтгүүлийн редакц:

Дугаар эрхэлсэн:  
Б.Урантуяа  
Ерөнхий редактор:  
О.Даваасүрэн  
Редактор:  
Б.Уртнасан,  
М.Дэлгэрмаа

Сэтгүүлч:  
Б.Урантуяа, Д.Мөнхжаргал  
Зурагчин:  
Г.Ган-Өлзий, Н.Батмөнх,  
А.Адъяажав  
Хэвлэлийн эх бэлтгэл:  
Б.Эрдэнэбилэг



Өнөр, Сүлжээ Дэлгүүр

Зах,  
Бөөний төв

НО РЕ КА



Дэлгүүр



ТӨСВИЙН ХӨДӨЛГӨӨН  
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН



# ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ

Хөрс эрүүл бол хүнс эрүүл - Хүнс эрүүл бол хүн эрүүл

Өрх айл



ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН

Түгээлт



Агуулах



Бэлтгэн  
нийлүүлэгч



Үйлдвэр



- Урамшуулал
- Техник
- Зээл
- Түлш
- Газрын хувь

- Тээвэрлэлт
- Нөөц
- Тохирсон бордоо

- Шинжилгээ
- Эрүүлжүүлэлт
- Талхлалт

- Нөөц
- Найрлага
- Усалгаа
- Гидрогеологи



ТЭРБУМ МОД  
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН



Үйлдвэрлэл



Лаборатори хяналт



Гурил

Мах



Өнгөг



Сүү



- НАССР
- ISO
- Стандарт
- Мал эмнэлэг
- Фермийн байр
- HR
- 300 техник
- ЗЭЭЛ
- ТЭЖЭЭЛ

- Тэжээлийн үйлдвэр
- Тоног төхөөрөмж
- Цаг агаар
- Үүл буудах
- ХАА гэмжих корпораши

- Амьтан, шавж судлал
- GMO
- Үрийн сан, банк
- Silo

- Үйлдвэрийн хүчин чадал
- ISO
- Эко
- Байгальд ээлтэй



Ферм

Улаан буудай, Тэжээл, буурцаг  
Ранс, Наран иезэг

Үр + Пестицид

Бордоо

Ус + Хөрс

"Хүнсний хувьсгал" Мэргэжлийн холбоо

Утас: 7799 0110

hunsniihuvisgal.mn